**TIBETAN STUDIES**
https://doi.org/10.5564/ts.v13i1.4719

Tom. XIII 2024 Fasc.14

༄༅། །བསྟན་པའི་རྩ་ལག་ཡོལ་གོག་སན་ཨེར་དེ་ནི་མེར་གེན་པཎྜི་ཏ་ཧུ་ཐོག་ཐུ་བློ་བཟང་བསྟན་པ་དར་རྒྱས་ཀྱི་
རྣམ་ཐར་ནོར་བུའི་མེ་ལོང་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ། །

༄༅༅། །སྒྲིབ་མེད་སྤྱན་རས་ཟུར་ཙམ་བཙས་བས་ཀྱང་། །ཕྲ་ཞིབ་བླང་དོར་གནས་ཀུན་འཁྲུལ་མེད་དུ། །
སྨྲ་བའི་བློ་དང་སྤོབས་པའི་མཆོག་སྦྱིན་པ། །འཇམ་མགོན་བསྟན་པའི་འཁོར་ལོས་ཞིས་པ་སྐྱོལ། །
བློ་བཟང་རྒྱལ་བསྟན་ཉིན་མོར་བྱེད་པ་ལ། །ཐུགས་བསྐྱེད་དར་བབ་འཕྲིན་ལས་འོད་སྟོང་གིས། །
ཕན་བདེ་སྣང་རྩེའི་དགའ་སྟོན་རྒྱས་མཛད་པ། །མཚུངས་བྲལ་འགྲོ་བའི་མགོན་པོ་རྒྱལ་སྒྲུར་ཅིག །
རྡོ་རྗེ་རྡོན་པོའི་གསང་གསུམ་སྒྱུ་འཕྲུལ་གར། །སྲས་བཅས་རྒྱལ་བའི་ལོངས་སྤྱོད་འཁོར་ལོ་རུ། །
བསྐལ་པའི་ཕྱི་མཐར་བཀྲམ་ཡང་གཏུགས་མེད་པ། །བློ་ཆུང་སྦྲང་བུའི་འདབ་མས་ཇི་ལྟར་གཞལ། །
གསེར་ལྡན་ཁོར་ཡུག་ཡངས་པའི་ནོར་སྦྱིན་ཕྱོགས། །ཐུབ་བསྟན་དབྱར་གྱི་ལང་ཚོས་ཟིན་པ་ན། །
མཁས་དང་གྲུབ་པའི་སྐྱེས་མཆོག་པདྨའི་འཕྲེང་། །ཀུན་ཀྱང་ལྗོངས་དེར་རྒྱན་དུ་ལྷགས་པ་བཞིན། །

**Шашны садан Ялгуусан эрдэнэ мэргэн бандида хутагт**
**Лувсандамбадаржаагийн намтар Чандманийн толь хэмээх оршвой**

[The Biography of Luvsandambadarjay, the Nobleman, the Wise Man,
the Great Treasure of the Religious Sect, the Mirror of Chandmani]

Түйтгэр үгүй мэлмийгээр өчүүхэн мэндэлсэн ч
Тун нарийн авал орхилын орон бүгдийг эндүүрэл үгүй
Тунгааж өгүүлэхийн оюун ба самбааны дээдийг өгөгч
Тэнцэшгүй Зөөлөн итгэлт шашны хүрд бээр өлзийг соёрх.
Тун Сайн оюунт ялгуусны шашныг гийгүүлэн үйлдэхэд
Тааллыг үүсгэсэн идэр залуу үйлсийн мянган гэрлээр
Тус амгалангийн зөгийний баяр хуримыг дэлгэрүүлэгч
Тэнцэхээс хагацсан амьтны итгэл ялах болтугай.
Хурц очрын гурван нууцын рид хувилгааны бүжиг
Хөвгүүн сэлт ялгуугсдын төгс эдлэхийн хүрдэн дор
Галавын эцэс сүүл хүртэл дэлгэсэн ч мухардах нь үгүй тул
Хөнгөн оюунт зөгийний далавчаар яахин хэмжиж чадах.
Бадарсан галаар хүрээлсэн Гүвэрагийн уудам зүг
Бурхан багшийн шашны зуны идрээр эзлүүлэхэд
Бүтээлч, мэргэн дээд төрөлхтний лянхуан эрхис
Бүгдээр мод түүнд чимэг болон ирэх мэт

སྣང་མཐའ་སྤྱན་རས་གཟིགས་བཅས་སྤྲུལ་པའི་གར། །རྒྱལ་དབང་ཡབ་སྲས་རྡོ་རྗེའི་བཀའ་ལུང་གིས། །
བསྟན་པའི་ཉི་མ་རིམ་བརྒྱུད་སྐྱེ་བའི་འཕྲེང་། །བསྔགས་པའི་མནྡཱ་ར་བ་ཅི་ཡང་འཐོར། །
ཨུཏྤལ་འདབ་ལྟར་ཡངས་པ་མཁྱེན་པའི་སྤྱན། །ལྡན་པ་གང་དག་མཛད་པའི་སྒོ་གཅིག་ནས། །
རྒྱན་གྱི་འཁོར་ལོའི་བཀོད་པ་རྫོགས་པའི་ཚུལ། །མངོན་པར་ཆུབ་པས་མོས་གུས་སྤྱུ་ལོང་གཡོ། །
འོན་ཏེ་ལྐོག་གྱུར་གནས་ལ་ཚད་མའི་ལུང་། །དཔང་དུ་བྱས་ཏེ་ཚུ་རོལ་མཐོང་བས་ཀྱང་། །
མངོན་པར་དམིགས་པའི་མཛད་པ་ཐུན་མོང་བ། །འགའ་ཙམ་དད་པའི་གསོས་སུ་སྦྱོལ་བར་བྱ། །
དགེ་ལེགས་རྣམ་པར་རྒྱལ་བའི་ཁང་བཟང་གི །རྨང་གཞི་དད་པའི་རྩ་བ་རབ་བརྟན་ཅིང་། །
ཚུལ་བཞིན་དཔྱོད་པའི་བློ་གྲོས་ཡངས་པ་རྣམས། །ཕྱོགས་ལྷུང་དོར་ཏེ་གུས་པས་བསྟེན་པར་མཛོད། །
དེའང་འཇམ་དཔལ་རྩ་རྒྱུད་ལས། །ཡི་གེ་ཧ་བྱ་དགེ་དང་ལྡན། །ཞེས་རི་བོ་དགེ་ལྡན་པའི་ལུགས་བཟང་བྱང་ནས་བྱང་གི་ཕྱོགས་མཐར་དར་བར་ལུང་བསྟན་པ་བཞིན་གྱི་དུས་ལ་བབས་པ་ན། དཔལ་འཕྲེང་སེང་གེ་ང་རོའི་མདོ་ལས་རྒྱལ་སྲས་ཀྱི་སྨོན་ལམ་མཐའ་ཡས་པ་ཐམས་ཅད་སྨོན་ལམ་ཆེན་པོ་གཅིག་གི་ནང་དུ་འདུས་ཤིང་ཆུབ་པ་ནི་དམ་པའི་ཆོས་འཛིན་པའི་སྨོན་ལམ་དུ་གསུངས་པ་དང་།

Амитаба, Логишура сэлтийн хувилгааны бүжиг
Эцэг хүү ялгуусны эрхт очрын зарлиг эшээр
Энэ шашны наран дараалан төрсний эрхис
Эрхэм сайшаалын Мандарва юу бээр ч тархах
Удвал цэцгийн дэлбээ мэт ууҗим мэлмий төгс
Ухаант мэргэдийн зохионгуйн гагц үүднээс
Чимгийн хүрдний байгуулал төгссөн ёсонд
Чинхүү нэвтэрвээс сүсэг бишрэлийн шар үс хөдлөх
Гэвч далд буй оронд шалгадаг эшийг
Гэрч болгон наашлуулан үзсэнээр
Тухайлан зоригдох нийтийн зохионгуй
Түүвэр төдийг сүсгийг арвижуулахаар холбоё.
Сайн буяны тийн ялсан сайн байшингийн
Суурь болсон сүсгийн ёзоор маш бат ба
Сайтар шинжлэгч ууҗим оюунтангууд
Сольж алагчлахыг орхиж бишрэлээр шүтэн зохио.

Тэр ч Жамбалзаржүд-с: “Үсгийн дуудлага буян лугаа төгөлдөр хэмээн Уулын төгс буянт (Гэлүгва)-ын сайн ёс умраас умар зүгийн хязгаарт дэлгэрэх”-ийг эш үзүүлсний цаг нь болоход цогийн эрхис Сэнгэ-арогийн судраас “бодисадын хязгаарлашгүй бүх ерөөл нэг том ерөөлийн дотор хураагдаж багтсан нь дээдийн номыг барихын ерөөл” гэж айлдсан.

ལུང་གཞན་ལས་ཀྱང་། དེ་ཚེ་གྲགས་ཆེན་རྒྱལ་སྲས་རྣམས། །ཕྱོགས་དེར་བསྟན་པ་འཛིན་པར་སྨོན། །ཞེས་གསུངས་པ་ལྟར། རྒྱལ་སྲས་བདག་ཉིད་ཆེན་པོ་རྣམས་ནི་ཡུལ་དང་དུས་གང་ན་སངས་རྒྱས་ཀྱི་བསྟན་པ་དར་བ་དེར་བསམ་བཞིན་སྐྱེ་བ་བཞེས་ནས་གདུལ་བྱའི་སྐལ་པ་དང་འཚམ་པར་ཐེག་པ་གསུམ་གྱི་བྱང་ཆུབ་ཏུ་བཀྲི་བར་མཛད་པ་ནི་རྒྱ་མཚོའི་རླབས་བཞིན་དུས་ལས་ཡོལ་བ་ནམ་ཡང་མི་སྲིད་པས། རྒྱལ་སྲས་བདག་ཉིད་ཆེན་པོ། ལུང་དང་རྟོགས་པའི་ཡོན་ཏན་གྱི་གཏེར་མཛོད། བྱང་ཕྱོགས་ཀྱི་སྐྱེ་འགྲོ་རྣམས་མཐོ་རིས་དང་ཐར་པར་འཁྲིད་པའི་འདྲེན་པ་བླ་ན་མ་མཆིས་པ༔ འཇམ་མགོན་བསྟན་པའི་རྩ་ལག་བློ་བཟང་བསྟན་པ་དར་རྒྱས་ཞེས་ཡོངས་སུ་གྲགས་པ་འདི་ཉིད་རླབས་པོ་ཆེའི་ཐུགས་བསྐྱེད་རྟ་ལྗང་ཤིང་རྟ་བདུན་གྱིས་དྲངས་ཏེ། སྐལ་བཟང་གདུལ་བྱའི་བསོད་ནམས་ཡངས་པའི་ལྷ་ལམ་ངོས་ལ་ཡང་ཡང་མངོན་པར་ཤར་ནས། སྐྱེ་དགུའི་ལེགས་བྱས་ཀྱི་པད་ཚལ་ཅིར་ཡང་བཞད་པར་མཛད་པའི་ཚུལ་ཀུན་གཟིགས་རྒྱལ་བའི་དབང་པོས་མཛད་པའི་འཁྲུངས་རབས་བདུན་མ་དང་། པཎ་ཆེན་ཐམས་ཅད་མཁྱེན་པས་མཛད་པའི་འཁྲུངས་རབས་བཅུ་གསུམ་མ་སོགས་ཡིད་ཆེས་པའི་ལུང་གིས་གསལ་བར་བསྟན་པ་ལྟར་ཡིན་ལ། དེའི་ནང་ནས་འདིར་འགའ་ཙམ་སྨོས་ན། སྟོབས་བཅུ་མངའ་བའི་མདུན་སར་ཁྱེའུ་སྣང་བ་བསམ་གྱིས་མི་ཁྱབ་པར་འཁྲུངས་ཏེ་སེམས་བསྐྱེད་པ་ནི་མཚོན་པ་ཙམ་ཡིན་ཏེ། བདག་ཅག་གི་སྟོན་པས་ཐུགས་བསྐྱེད་ཚུལ་ལའང་དྲིན་ལན་བསབ་པ། མདོ་སྡེ་བསྐལ་བཟང་། པད་དཀར། མྱང་འདས། རབ་གསལ་གྱི་རྟོགས་བརྗོད་སོགས་ལས་མི་འདྲ་བ་སྣ་ཚོགས་གསུངས་པ་ལྟར། དམ་པ་འདིའང་རྔོག་ལེགས་པའི་ཤེས་རབ་ཀྱི་སྐྱེ་བར་གསུངས་ལ།

Бусад эшээс ч “Тэр цагт их алдарт бодисадва нугууд Тэр зүгт шашныг барихыг ерөөе” хэмээсэн мэт дээд төрөлхтөн бодисадва нугууд нь ямар оронд, хэзээ бурхны шашныг дэлгэрүүлэх, түүгээрээ санаснаараа төрөл авч шавийн хувьд тааруулан гурван хөлгөний гэгээрэлд хөтлөн зохиодог нь далайн давлагаа мэт цагаас өнгөрөх нь хэзээ ч үл болох тул их төрөлхтөн бодисадва, эш онолын эрдмийн гуу сан, умар зүгийн амьтны сайн төрөл, гэгээрлийн дээр үгүй удирдагч, Зөөлөн итгэлтийн шашны садан Лувсандамбадаржаа хэмээн огоот алдаршсан тэр ямагт агуу их таалллын нарыг үүсгэн шулуудаж хувь төгс шавийн уужим буяны огторгуйд дахин дахин мандаад хамаг амьтны сайн үйлийн лянхуан цэцэрлэг юутай ч мишээн зохиосон ёсыг хамгийг болгоогч Ялгуусны эрхтийн зохиосон долоон төрлийн үе, Банчин хамгийг айлдагчийн зохиосон арван гурван төрлийн үе тэргүүтэн итгэж болохуйц эшээр тодруулан үзүүлсэн ба түүний дотроос энд зарим төдийг нь өгүүлье.

Бурхан багшийн үед Нанвасамжимичав хүү болж мэндлээд сэтгэл үүсгэсэн нь бэлгэдэл төдий бөгөөд бидний Бурхан багш таалал үүсгэсэн ёс нь ч Ачийн хариуг хариулсан, Судрын аймаг сайн хувьт, Цагаан лянхуа, Гаслангаас нөгчсөн, Равсалын түүх тэргүүтэнд адилгүй олон янзаар өгүүлсэнчлэн энэ дээдэс ч Ог Лэгвишэравын дараа төрөл гэж зарлигласан.

དེ་ནི་ཇོ་བོ་ཡབ་སྲས་དང་སྐུ་འཕྲེང་དུ་མར་འབྲེལ་ཏེ་རྒྱལ་སྲས་ཀྱི་སྤྱོད་པ་ལ་བསླབ་ཚུལ་བཀའ་གདམས་གླེགས་བམ་ལས་འབྱུང་བ་ལྟར་རོ། །དེར་མ་ཟད་ཁུ་རྔོག་འབྲོམ་གསུམ་འཕགས་པ་རིགས་གསུམ་མགོན་པོ་དང་སྦྱར་བའི་ཚེ་རྔོག་འཇམ་དཔལ་གྱི་རྣམ་འཕྲུལ་དུ་གསུངས་ལ། དེ་ལྟར་ན་ཟླ་བས་འཇུག་འགྲེལ་དུ། འཕགས་པ་འཇམ་དཔལ་བྱང་ཆུབ་སེམས་དཔར་གྱུར་པ་ཉིད་ཀྱིས་དེ་བཞིན་གཤེགས་པ་ཤཱཀྱ་ཐུབ་པ་ལ་སོགས་པ་སེམས་བསྐྱེད་པ་འཛིན་དུ་གཞུག་པར་འདོད་པ་ཡིན་ནོ། །ཞེས་བཤད་པ་ལྟར་རྒྱལ་བ་ཀུན་གྱི་ཡབ་ཏུ་གྱུར་པ་དང་། རྒྱལ་བ་ཀུན་གྱི་སྲས་ཀྱི་ཐུ་བོའི་ཚུལ་འཛིན་པ་སོགས་གསང་བ་བསམ་གྱིས་མི་ཁྱབ་པའི་གནས་ནི་སློ་བསམ་གྱི་ར་བ་ལས་འདས་སོ། །ཐུན་མོང་བ་ལྟར་ནའང་ལྷ་ཆོས་བདུན་ལྡན་གྱི་བཀའ་གདམས་ནོར་བུའི་ཕྲེང་བའི་བདག་པོར་གྱུར་ཏེ། མན་ངག་བྱིན་རླབས་ཀྱི་བརྒྱུད་པའི་རྩ་བ་འདི་ཉིད་ལ་ཐུག་གོ །དེ་བཞིན་དུ་ཤར་ཆེན་ཡེ་ཤེས་རྒྱལ་མཚན་ཡང་མཁྱེན་བརྩེ་ནུས་པ་མངོན་ཤེས་རྫུ་འཕྲུལ་སོགས་ལ་དབང་འབྱོར་ཅིང་། ངོར་ཆེན་སོགས་སྐབས་དེའི་ས་སྐྱའི་བསྟན་འཛིན་ཀུན་གྱིས་གཙུག་རྒྱན་དུ་བཀུར་ཏེ་གསུང་ངག་ལམ་འབྲས་ཀྱི་གདམས་པའི་བདག་པོར་གྱུར་པ་དང་། དེ་ནས་ཁྲི་ཐོག་བཅུ་དྲུག་པ་རྒྱ་ར་ཀུར་བ་ཆོས་སྐྱོང་རྒྱ་མཚོའང་རྗེ་བླ་མའི་མདོ་སྔགས་ཀྱི་ཆོས་ཚུལ་མཐའ་དག་ཐུགས་སུ་ཆུད་དེ་བྱང་རྩེ་དང་དགའ་ལྡན་གྱི་ཁྲིར་ཕེབས༑ ཐུབ་པའི་གོས་སྐུ་ཆེན་མོ་བཞེངས་པ་སོགས་མཛད་པ་རླབས་ཆེ་ཞིང་།

Тэр нь Жово эцэг хүү лугаа олон төрлийн барилдлагатай, бодисадын явдалд суралцсан ёс нь Гаадамбын номоос гарсан мэт болой. Түүгээр үл барам Хү, Ог, Бром гурвыг хутагт язгуурын гурван бурхантай барилдуулах цагт Ог нь Манзушрийн хувилгаан гэж зарлигласан. Тэгвэл Чандрагирди “Төвд орохуйн тайлбар”-т хутагт бодисадва Манзушир өөрөө Бурхан багш тэргүүтнийг сэтгэл үүсгэхэд оруулсан гэж гардаг болой хэмээн номлосон мэт ялгуусан бүгдийн эцэг болсон ба ялгуусан бүгдийн хөвгүүдийн ахмадын ёсыг барьсан тэргүүтэн нууц санаанд багташгүй орон нь өгүүлэх, санахын хүрээнээс хэтэрсэн болой. Нийтийн ёсоор ч бурхны долоон ном төгс Гаадамбын “Эрдэнийн эрих”-ийн эзэн болсон бөгөөд увдис, адистидын дамжлагын уг энд тулах болой.

Түүнчлэн шарчэн Ишжанцан ч айлдал энэрэл, чадал, илт мэдэл, рид хувилгаан тэргүүтнийг эрхшээсэн ба Орчэн тэргүүтэн тэр үеийн сажын ёсыг баригч бүгдээр оройн чимэгт хүндэлсэн зарлиг, мөр, үрийн увдисын эзэн болсон.

Түүнээс XVI ширээт жарагүрва Чойжонжамц ч Богд Зонхавын судар тарнийн номын ёс даяарыг таалалдаа багтааж Жанзэ болон Гандангийн ширээнд залрав. Бурхны их том лагшин бүтээсэн тэргүүтэн зохионгуйн давлагаа их бөгөөд

སྨད་རྒྱུད་ཀྱི་ཁྲིད་ཆེན་བརྒྱད་ཀྱང་འདི་ཉིད་ཀྱིས་མཛད་དེ་དགེ་ལྡན་བསྟན་པའི་བདག་པོར་གྱུར་པ་སོགས་རྒྱ་བོད་ཀུན་ཏུ་མཁས་གྲུབ་ཀྱི་སྐྱེ་འཕྲེང་དུ་མ་བཞེས་ནས་བསྟན་པའི་སྲོག་བཟུང་བ་ཡིན་ལ། དེ་ནས་དུས་ཀྱི་རིམ་པས་བྱང་ཕྱོགས་ཆེན་པོ་ཧོར་གྱི་ཡུལ་དུ་བློ་བཟང་རྒྱལ་བའི་བསྟན་པ་སྤེལ་བའི་ཐུགས་བསྐྱེད་འཕྲིན་ལས་ཀྱི་དུས་ལ་བབས་པ་ན། ཐུགས་རྗེ་དང་མཁྱེན་པ་ཟུང་དུ་འཇུག་པས་འགྲོ་ཀུན་ཐར་པའི་ལམ་དུ་བཀྲི་བ་ལ་འཕྲིན་ལས་ནམ་མཁའ་དང་མཉམ་པ་འགྲོ་མགོན་བསྟན་པའི་ཉི་མ་དང་། དེའི་ཡང་སྲིད་ལུས་ཅན་མཐའ་དག་ལ་བརྩེ་བའི་གཞན་དབང་དུ་གྱུར་པ་བདག་ཉིད་ཆེན་པོ་རྗེ་བཙུན་བསྟན་པའི་རྒྱལ་མཚན་སོགས་སྐུ་འཕྲེང་གོང་མ་སོ་སོའི་རྣམ་ཐར་རྒྱས་པ་གཞན་ལས་ཤེས་པར་བྱ་ཡི་འདིར་དཔྱོད་པའི་སྒོ་ཙམ་བསྟན་པ་ཡིན་ནོ། །

དྲི་བྲལ་དངས་པའི་ཤེལ་གྱི་མེ་ལོང་ནི། །ཚོན་བརྒྱར་འགྲོགས་པའི་མདངས་སུ་གསལ་བ་བཞིན། །
གང་ལ་གང་འཚམ་གདུལ་བྱའི་སྐལ་བ་དང་། །མཐུན་པར་བསྟན་པའི་བཀོད་པ་བསམ་མི་ཁྱབ། །
རྒྱལ་བའི་ཆོས་ཀྱི་གསང་མཛོད་འཕགས་ལམ་གྱི། །ཡན་ལག་བརྒྱད་ལྡན་གླུང་ཆེན་འབབ་པའི་ཕྱོགས། །
དེ་ན་ཐབས་ཤེས་གཞོག་ཡངས་གོམ་པ་ཡིས། །རྒྱལ་སྲས་ཆུ་སྐྱར་ཚོགས་རྣམས་ལྡིང་ཞིང་རྩེན། །
དེ་ནས་སྐྱེ་བའི་འཕྲེང་བ་འདི་ཉིད་བཞེས་ཏེ་བསྟན་འགྲོའི་མགོན་མཛད་པའི་ཚུལ་ནི། བྱ་རའི་ལུང་ཕོ་ནམ་པ་ལ་རྫིང་

Маджүдийн найман их хөтөлбөрийг ч энэ ямагт бээр зохиож Төгс буянтын шашны эзэн болсон тэргүүтэн Энэтхэг, Төвөд бүхэнд мэргэн, бүтээлчийн төрлийн хэлхээ олныг таалж шашны амин голыг барьсан.

Түүнээс цагийн дараалаар умар зүгийн Их монгол оронд Сайн оюунтны шашныг арвижуулах таалал үүсгэсэн үйлсийн цаг болоход нигүүлсэхүй хийгээд айлдал хослон орсноор амьтан бүгдийг гэгээрлийн замд хөтлөхөд үйлс нь огторгуй лугаа сацуу, амьтны итгэл Дамбийням, түүний дараа дүр амьтан бүгдийг өөрийн эрхгүй энэрэгч их төрөлхтөн, гэтэлгэгч Дамбийжалцан тэргүүтэн урд дүрүүдийн тус тусын намтрыг дэлгэрэнгүй бусдаас мэдэж үйлдээрэй. Энд судлахын эхлэл төдийг үзүүлсэн болой.

Асар тунгалаг хиргүй шилэн толинд
Зуун өнгө нийлсэн ч өнгө нь тодорхой мэт
Алинд алин зохицох шавийн хувь лугаа
Зохилдуулан үзүүлсэн байгуулал санаанд багташгүй.
Ялгуусны номын нууц гуу сан хутагтын мөрийн
Яндашгүй найман гишүүн төгөлдөр их мөрөн буусан зүгт
Ямагт арга билгийн ууҗим жигүүрээр дэвсээр
Ялгуусны хөвгүүн цахлайн чуулган халин наадмуй.

Түүнээс төрлийн эрхсийг энд болгоож шашин амьтны итгэл болсон ёс нь эгнэсэн хөндийд Онон балжин

ཞེས་པའི་ཀླུང་ཆེན་གྱི་འགྲམ་དུ་རྒན་པོ་ཚེ་དབང་བྱ་བ་དང་རྒན་མོ་དགེ་འཕེལ་བྱ་བ་རིགས་རྒྱུད་མེད་ཅིང་ལོངས་སྤྱོད་ཀྱིས་དབུལ་བས་ཤིན་ཏུ་ཉམ་ཐག་པ་གཉིས་ཡོད་པར་བརྩེ་བས་དགོངས་ཤིང་རྗེས་སུ་འཛིན་པའི་སྐལ་བ་ཅན་དུ་དགོངས་ཏེ་བྱོན་པ་ཡིན་ནོ། །དེའང་རབ་བྱུང་བཅུ་གསུམ་པའི་བགྲང་བྱ་བཅུ་གཅིག་པ་སྟོང་འགྲེལ་ལྟར་ན་ཨི་ཤྭ་ར་སྟེ་དབང་ཕྱུག །ཅི་ནའི་སྐད་དུ་ཁང་ཚེའུ། དབང་ཐང་བསྟུན་པ་མེ་མོ་གླང་གི་ལོ་འབྲས་ལྡན་གྱི་དུས་སུ་རྒན་མོ་དེ་ཉིད་ལྕི་བ་འཐུ་བར་སོང་བའི་ཚེ་ཆུ་འགྲམ་གྱི་གད་རྫ་ཞིག་ཏུ་བདག་པོ་མེད་པར་བྱིས་པ་ཤིན་ཏུ་ཆུང་དུ་ཞིག་འདུག་པ་མཐོང་ཙམ་ནས་ཡིད་དུ་འོང་བའི་དགའ་བ་ཆེན་པོ་དང་བུའི་འདུ་ཤེས་སྐྱེས་ནས་བླངས་ཏེ། འདི་ནི་ཆེད་དུ་བརྗོད་པའི་ཚོམ་ལས། གང་ན་དམ་པ་བཞུགས་པ་ཡི། །ས་དེ་ཡིད་དུ་འོང་བ་ཡིན། །ཞེས་པ་ལྟར་བྱམས་པ་གོམས་པའི་བདག་འབྲས་དང་ལས་འབྲེལ་གྱི་མཐུར་མངོན་ནོ། །སློབ་དཔོན་པདྨ་རྫུས་སྐྱེས་སུ་གྲགས་པའི་རྒྱ་བའང་འདི་འདྲ་ཞིག་ལ་བརྟེན་པའི་ལོ་རྒྱུས་ཡོད་ལ། རྗེ་བཙུན་ཏཱ་ར་ནཱ་ཐས་མཛད་པའི་སློབ་དཔོན་གྱི་རྣམ་ཐར་རྒྱ་གར་ལུགས་ལས་ཡབ་ཡུམ་གྱི་མིང་དང་བཅས་པ་གསུངས་སོ། །དེ་ནས་ཁོང་གཉིས་ཀྱིས་བུ་བཞིན་གཅེས་པར་བསྐྱངས་པས་རྫིང་གི་པདྨ་བཞིན་དུ་ལང་ཚོ་འཕེལ་ཞིང་། དེ་ཕྱིན་ཆད་ཁོང་གཉིས་ཀྱང་སྔར་དང་མི་འདྲ་བར་འཚོ་ཆས་སོགས་རྙེད་སླ་བས་དགའ་སྤྲོ་དང་ལྡན་པར་གྱུར། རྒན་མོ་རང་བཞིན་གྱིས་དྲང་ཞིང་སྙིང་རྗེ་ཆེ་བ་ཞིག་ཡིན་པའི་སྟེང་དུ་དམ་པ་འདི་ཉིད་ཕེབ་པའི་བྱིན་རླབས་ཀྱིས་དཀོན་མཆོག་ལ་ཤིན་ཏུ་གུས་ཤིང་། གང་འབྱོར་གྱི་སྦྱིན་པ་ལ་སྤྲོ་བ་རྒྱས་ཏེ།

хэмээх их мөрний хөвөөнд өвгөн Цэвээн, эмгэн Гэмпэл хэмээх язгуур угсаагүй, эдээр хоосорсон, машид дорой буурай хоёр буйг энэрлээр таалж тэтгэн дэмжүүлэх хувьтанд таалан заларсан болой. Тэр нь ч XIII жарны арван нэгдэх жилд, тайлбар мэтээр Эшваар бөгөөд Эрх баялагт, хятадын хэлээр Ханцэү, буян хишиг зохилдсон гал үхэр жилийн навч үр төгс цагт эмгэн тэр аргал түүхээр одох цагт усны захын нэг эрэгт эзэнгүй маш жижиг нялх \хүү\ нэгэн байхыг харсан төдийд сэтгэлд зохистой их баясал болж хүүгээ гэж бодон авсан бөгөөд энэ нь Тухайлан өгүүлэхийн цоморлогоос: “Хаана дээдэс оршин, Тэр газар сэтгэлд зохистой мөн” хэмээсэн мэт асрахуйг дадуулсны эзлэх үр ба үйлийн барилдлагын хүч нь илэрхий болой. Ловон Бадамжунай хувилж төрсөн гэдгийн үндэс нь ч үүнтэй адил нэгэн дээр тулгуурласан түүх байгаа ба гэтэлгэгч Даранатын зохиосон Ловон Бадамжунайн намтарт энэтхэг ёсоор эцэг эхийн нэр лугаа сэлтийг зарлигласан болой.

Тэндээс тэр хоёр хүү мэт энхрийлэн тэтгэснээр цөөрмийн лянхуа мэт идэр залуу нь арвидаж хойшид тэр хоёр ч урдынхтайгаа адилгүй эд агуурс олдох нь хялбар болж баяр хөөртэй болов. Эмгэн угаас шударга, их энэрэнгүй нэгэн байсны дээр дээдэс энэ заларсны адистидаар чухаг дээдэд машид бишрэлтэй бөгөөд аль олсноо өгөхөд дуршилтай,

རྒྱུས་ཡོད་མེད་ལ་མ་ལྟོས་པར་ཐག་རིང་གི་མགྲོན་པོ་ངལ་དུབ་ཀྱིས་གདུངས་པ་རྣམས་ལ་འཚོ་བ་སྟོབ་པ་སོགས་རྣམ་དཀར་ལ་བརྩོན་པར་གྱུར། བྱིས་པ་དེའང་ཐ་མལ་གྱི་བྱིས་པ་གཞན་དང་མི་འདྲ་བར་རྩེད་མོ་བྱེད་པའི་ཚེའང་ས་རྡོ་ཤིང་སོགས་ལ་སངས་རྒྱས་དང་མཆོད་རྟེན། བླ་མ་དགོན་པ་སོགས་ཀྱི་མིང་བཏགས་ནས་བསྒྲིགས་ཏེ་ཆོས་བཤད་པ་དང་དགོན་འདེབས་པ་སོགས་ལེགས་པའི་རྟེན་འབྲེལ་དུ་འགྱུར་བ་ཁོ་ན་མཛད། སྐྱེ་བས་ཐོབ་པའི་ཡོན་ཏན་གྱིས་དཀོན་མཆོག་ལ་མཆོད་པ་དང་། གཟུངས་སྔགས་བཟླས་བརྗོད་ལ་བརྩོན་པ། འགྲོ་བ་ལ་སྙིང་བརྩེ་བ། མངོན་ཤེས་དང་ནུས་མཐུ་ལྡན་པ་སྟེ། མ་རྒན་གྱི་མིག་ན་བའི་ཚེ་བསང་ཤིང་གིས་བདུག་པའི་རྣམ་པ་བྱས་པས་མྱུར་དུ་བདེ་བ་དང་། མིག་ལ་ལིང་ཏོག་བྱུང་བ་འགའ་ཞིག་ལ་ཐུག་གིས་བྱུག་པས་ནད་ཞི་བ་དང་། ལ་ལར་ཁྱོད་ཀྱི་ནད་འདི་ལོ་ཟླ་འདི་ཙམ་ན་སོས་ཡོང་ཞེས་གསུང་བ་དེ་ཁོ་ན་བཞིན་གྱུར་པས་ངོ་མཚར་གྱི་གནས་ལ་བཀོད་དེ། ལམ་སྒྲོན་ལས། མངོན་ཤེས་ལྡན་པའི་ཉིན་མཚན་གྱི། །བསོད་ནམས་དག་ནི་གང་ཡིན་ཏེ། །མངོན་ཤེས་དག་དང་བྲལ་གྱུར་ལ། །སྐྱེ་བ་བརྒྱར་ཡང་ཡོད་མ་ཡིན། །གསུངས་པ་ལྟར་གཞན་དོན་རླབས་པོ་ཆེ་འགྲུབ་པའི་རྒྱུ་ལ་དབང་འབྱོར་པའི་རྣམ་ཐར་རོ། །སྐབས་ཤིག་རི་གྲིབ་ཀྱིས་གསུང་ངག་མི་གསལ་བ་ཞིག་བྱུང་ཡང་རིམ་གྱིས་ཇེ་དངོས་སུ་སོང་། དགུང་ལོ་བདུན་པའི་ཚེ་ཡབ་ཡུམ་གཉིས་རྒྱལ་པོའི་ཁྲལ་གྱིས་ཧོབ་ཏེ་ཞེས་པའི་ས་ཆར་འོངས། སྔ་ཕྱིའི་མཛད་པ་ཡ་མཚན་པ་རྣམས་ལ་བརྟེན་ནས་ཡབ་ཡུམ་གཉིས་ངོགས་པ་སྐྱེས་ཤིང་།

таних танихгүй нь хамаагүй хол ойрын алжааж зүдэрсэн зочдод тэжээл (идээ) өргөх тэргүүтэн буянд хичээх болов. Хүү ч бусад эгэл хүүхдүүдтэй адилгүй ба тоглоомоо тэмдэглэх үедээ ч чулуу, мод тэргүүтнийг бурхан, суварга, багш итгэл тэргүүтнээр нэрлэж өрөөд ном номлох, хийд барих тэргүүтэн сайн шүтэн барилдлага болох ямагтыг зохиов. Төрөхөөс олсон эрдмээр чухаг дээдийг тахих, тогтоол тарни урьж өгүүлэхэд хичээх, амьтныг энэрэн нигүүлсэх, илт мэдэл, чадал хүч төгөлдөр бөгөөд настай ээжийнх нь нүд өвдөх үед сангийн модоор утах байдлаар үйлдсэнд түргэн эдгэх, нүдэнд нь цагаа гарсан зарим нэгнийг мутраараа арчсанаар өвчин нь амарлих, зарим нэгэнд “таны өвчин энэ жилийн энэ сард эдгэнэ” хэмээн айлдсан нь түүнчлэн болсноор гайхширахын оронд байгуулсан ба Мөрийн зул-аас: “Илт мэдэл төгссөнөөр өдөр шөнө Алинд ч буян байх бөгөөд Илт мэдэл лугаа хагацваас Алин зуун төрөлд ч байх бус” хэмээн зарлигласан мэт бусдын тусыг агуу ихээр бүтээсэн угаар баялаг намтар болой. Нэг удаа үхээрийн бузраар хэл үг нь тодорхойгүй нэгэн гарсан ч аажмаар тодорхой болж одов.

Долоон нас хүрэх үед эцэг эх хоёр нь хааны алба татвараар Ховд хэмээх газарт ирсэн. Урд хойдын гайхамшигт зохионгуйгаас болоод эцэг эх хоёр нь эргэлзэж,

དཔྱོད་ལྡན་གྱི་སྐྱེས་བུ་གཞན་རྣམས་ཀྱང་འདི་རང་ག་བ་ཞིག་མིན་པར་འདུག་ཅེས་གླེང་བ་བྱུང་བའི་ཐོག །ཉིན་གཅིག་གློ་བུར་དུ་ངེད་ཡིལ་གོག་སན་ཏུ་ཐོག་ཐུ་ཡིན་ཞེས་གསལ་བར་གསུངས། དགུང་ལོ་བཅུ་པའི་སྐབས་རྨི་ལམ་དུ་མདུན་གྱི་ནམ་མཁའ་ལ་མཾ་ཡིག་ཁ་དོག་དམར་པོ་འོད་འཚེར་བ་ཞིག་འདུག་པའི་འོད་ཀྱིས་འཛམ་གླིང་གི་སྣོད་བཅུད་ཐམས་ཅད་གསལ་བར་བྱེད་པ་བྱུང་བ་ནི་བྱམས་མགོན་གྱིས་རྗེས་སུ་འཛིན་པ་དང་འཕྲིན་ལས་ཕྱོགས་མཐར་རྒྱས་པའི་ལྟས་སུ་མངོན། དགུང་ལོ་བཅུ་གཉིས་པའི་ཚེ་ཡབ་རྒན་དུས་ཆོས་སུ་གྱུར་བར་ཅི་འབྱོར་གྱི་དགེ་བ་བསྒྲུབས། དེ་ནས་གཞན་ལས་བཟའ་བཏུང་སོགས་བསླངས་ཏེ་རྒན་མོ་རང་གི་མ་དང་འདྲ་བར་དྲིན་ཆེ་བར་དགོངས་ནས་ཤིན་ཏུ་བཀུར་ཞིང་གསོ་བར་མཛད་པའང་དམ་པའི་ངང་ཚུལ་ཡིན་ཏེ། དཔག་བསམ་འཁྲི་ཤིང་ལས། དེ་སྐད་མ་ཡི་སྲི་ཞུ་ནི། །ཆོས་ཀྱི་མཆོག་ཏུ་བཅོམ་ལྡན་གསུང་། །ཞེས་པ་ལྟར་རོ། །ཕྱོགས་གཞན་ལ་འཚོ་བ་སློང་བར་ཕྱིན་ནས་ཕྱིར་ལྡོག་པའི་ལམ་དུ་བྱ་ཁྱི་ལྟོགས་པ་མང་པོ་གཟིགས་ནས་གང་རྙེད་དེ་དག་ལ་བྱིན་ཏེ་ཕྱིར་ལག་སྟོང་དུ་འོང་བའི་དུས་མང་ལ། རེས་འགའ་ཕྱག་ན་སྟེར་རྒྱུའི་ཟས་མེད་པའི་ཚེ་བཙན་ཐབས་ཀྱིས་བསྐྱུགས་ཏེ་དེ་དག་ལ་བྱིན་ནས་ཚིམ་པར་མཛད། འདིའང་བྱང་ཆུབ་སེམས་དཔའི་སྡེ་སྣོད་ལས་སྦྱིན་པ་ལ་ཕྱི་དང་ནང་དང་གཉིས་ཀའི་སྦྱིན་པ་གསུམ་དུ་བྱས་པའི་ཕྱི་མར་གསུངས་ཏེ༑ སྙིང་རྗེས་རང་དབང་མེད་པར་བསྐྱུལ་བའི་མཛད་པ་ངོ་མཚར་རྨད་དུ་བྱུང་བའོ། །དབུ་མ་འཇུག་པར། རང་ཤ་སྟེར་ལའང་གུས་པར་བྱས་པ་ཡིས། །སྣང་དུ་མི་རུང་དཔོག་པའི་རྒྱུར་ཡང་འགྱུར། །

шинжлэл төгс бусад хүмүүсийн дунд ч энэ эгэл нэгэн биш байна хэмээн яриа гарсны дээр нэг өдөр гэнэт “би Ялгуусан хутаг мөн” хэмээн тодорхой айлдсан.

Есөн настай байх үеийн зүүдэнд өмнийн огторгуйд гэрэл гялалзсан улаан өнгийн МАМ үсэг байгаагийн гэрлээр Замбуутивийн сав шим бүгдийг тодруулан үйлдэж буйгаар гарсан нь Майдар бурхан тэтгэн дэмжиж үйлсийг нь зүгийн эцэст дэлгэрүүлэхийн ёр гэдэг нь илэрхий. Арван хоёр настай байх үед хөгшин эцэг нь нас нөгчсөнд аль буйгаараа буяныг бүтээв. Тэгээд бусдаас идээ ундаа гуйж эмгэнийг өөрийн эх мэт их ачтай гэж болгоон машид хүндлэн тэжээн зохиосон нь ч дээдсийн авир ёс мөн. Галбарваасан мод-оос: Тийн хэмээн эхийн өргөл хүндлэлийг номын дээдэд бурхан айлдсан” хэмээсэн мэт болой. Өөр тийш амь зуух эд гуйхаар очоод буцах замдаа өлсгөлөн шувуу, нохой олныг үзээд аль олсноо тэдгээрээ өгөөд гар хоосон буцах үе ч олон байв. Заримдаа гарт нь өгөх идээ байхгүй бол хүчээр бөөлжөөд түүнийгээ өгч баясан зохиов. Энэ нь ч бодисадвагийн аймаг саваас өглөгт гадаад, дотоод, хоёулын өглөг гуравт үйлдсэний гадаад гэж зарлигласан бөгөөд нигүүлсэхүйгээр өөрийн эрх үгүйг сануулсан зохиол гайхамшигтай болой. Төвд орохуй-д: “Өөрийн махыг өгөхөд ч бишрч үйлдмүй, Үзэгдэлд эс болсныг шинжлэхийн уг ч болмуй”

ཞེས་པ་ལྟར་སྦྱིན་པ་ལ་ལྷག་པར་དགྱེས་པ་ནི་ནང་གི་བྱམས་པ་དང་སྙིང་རྗེའི་ནུས་པ་རྗེས་སུ་དཔོག་པའི་མཚན་མ་ཡིན་ཏེ། ཁྭ་ཏ་དང་སྐྱ་སོགས་བྱ་རྣམས་ཀྱང་མི་སྐྲག་པར་སྐྱུ་དྲུང་དུ་བསྟེན་པ་ནི། སྔོན་རྣལ་འབྱོར་པ་ཆེན་པོའི་དྲུང་དུ་རི་བོང་གི་ཕྲུག་གུ་ཞིག་འོངས་ནས་རྩེ་བ་དང་། ཝ་ཞིག་ན་བཟའ་ལ་སྣོམ་ཞིང་ཕྱི་བཞིན་འབྲང་བ་སོགས་བྱམས་པ་གོམས་པའི་འབྲས་རྟགས་སུ་གསུངས་པ་བཞིན་ནོ། །འབྱོར་བ་ཆུང་ཡང་རང་བཞིན་བཟང་ཞིང་འགྲོགས་ན་བདེ་བ། མགྲོན་གྱི་བསྟེན་བཀུར་སོགས་ལ་འབད་པའི་དབང་གིས་སྐྱེ་བོ་དྲག་ཞན་སྣ་ཚོགས་འདུ་བ་ཞིག་ཡོད་པས། ཉིན་གཅིག་མི་བཅུ་གསུམ་འོངས་པར་མ་ལ་བཟའ་བཏུང་སྦྱིན་རྒྱུའི་སྐུལ་མ་བྱས་པ་ན་ཅིའང་མེད་པས་ཐབས་མི་འདུག་ཟེར་བ་ལ། མཆོད་པའི་ལྷག་རོ་ཁྲི་དང་འོ་མ་ཕོར་ཆུང་གང་རེ་ཙམ་འདུག་པ་འདི་བཙོས་ནས་བྱིན་བྱས་པར། འདིས་ཅིའང་མི་འདང་བས་དགོས་པ་མེད་བྱས་ཀྱང་ངེས་ཤེས་ཞེས་ནན་གྱིས་འཚོད་དུ་བཅུག་སྟེ་བྱིན་པས་ཐམས་ཅད་འགྲུབ་པར་ད་དུང་མི་ཟད་པའི་རྫུ་འཕྲུལ་ལྟ་བུ་བསྟན་ནས་ཐམས་ཅད་ངོ་མཚར་ལ་བཀོད། ལན་ཅིག་མི་ཚང་གཞན་ཞིག་གི་ཁྱིམ་དུ་གཟིམས་པའི་ཚེ་ཁྱིམ་གྱི་ནང་ཐམས་ཅད་འོད་ཀྱིས་གང་སྟེ་ཡོ་བྱད་ཆུང་ངུ་རྣམས་ཀྱང་གསལ་བར་མཐོང་བ་ན། དེའི་བཟའ་མི་གཉིས་ཀས་བྱིས་པ་འདིའི་མཐུ་ཡིན་པར་ཤེས་ནས་གུས་འདུད་བྱས། གནས་བརྟན་འདུལ་བ་འཛིན་པ་བློ་བཟང་རིན་ཆེན་དཔལ་བཟང་པོ་ལས་རབ་ཏུ་བྱུང་ནས་མཚན་བློ་བཟང་བསྟན་པ་དར་རྒྱས་སུ་གསོལ་ཞིང་དཀྲུས་གཅིག་ལ་དགེ་ཚུལ་གྱི་སྡོམ་པའང་བཞེས་ཏེ་བསླབ་པའི་གཞི་བཅུས་བསྡུས་པའི་ཚུལ་ཁྲིམས་ལེགས་པ་བསྲུང་ཞིང་ཐོས་བསམ་ལའང་སྐབས་གང་ཡོད་དུ་འབད་པ་ལྷུར་བཞེས་པས་རྒན་མོའི་བཙུན་ཞེས་ཡ་རབས་ཚུལ་བཟང་གི་དཔེར་བྱེད་པ་བྱུང་།

хэмээсэнчлэн өглөгт илүү баясах нь доторх асрал, нигүүлслийн чадлыг хэмжих тэмдэг бөгөөд хэрээ, шаазгай тэргүүтэн шувууд ч үргэлгүй ойртдог нь урьд их бясалгагчийн дэргэд нэгэн туулайн бүжин ирж тоглосон, нэгэн үнэг дээлийг нь үнэрлэж даган явсан тэргүүтэн асралыг дадуулсны үр дагавар гэж айлдсанчлан болой. Хөрөнгө чинээгүй ч сайхан ааштай, нөхөрлөхөд тайван, зочдыг хүндлэх тэргүүтэнд шамдсаны эрхээр сайн муу бүхэн цугладаг болсноор нэг өдөр 13 хүн ирж ээжийг нь идээ унд өгөхийг шаардсан ч өгөх юм юу ч байхгүй тул арга алга, тахилын будааны үлдэгдэл шавхруу, нэг жижиг аяга сүү л байна, үүнийг буцалгаж өгье гэсэнд энэ хаанаа ч хүрэлцэхгүй тул хэрэггүй гэцгээсэн ч “итгэ” хэмээн хүчээр буцалгуулж өгсөнд бүгд цадсан ч үл барагдах рид хувилгааныг үзүүлж бүгдийг нь гайхшируулав. Нэг удаа өөр нэг айлд унтаж байтал гэр гэрлээр дүүрч доторх эд хогшил бүхэн тодорхой үзэгдсэнд тэр айлын эхнэр нөхөр хоёулаа энэ хүүгийн хүч гэж мэдээд бишрэн сөгдөж үйлдэв. Найдан винайг баригч Лувсанринчен сайн цогтоос сахил хүртсэнд алдрыг нь Лувсандамбадаржаа хэмээн соёрхсон бөгөөд үргэлжлүүлэн гэцлийн санваарыг ч хүртэж суртгаалын арван сууринд хураагдах шагшаабадыг сайтар сахиж сонсох, санахад ч үргэлж шамдан “Эмгэний банди” хэмээн дээдсийн сайн ёсны үлгэр жишээ болов.

ཡོངས་སྤྱོད་ཁ་དྲག་ཅིའང་མེད་པས་གནད་མ་གོ་བ་རྣམས་བརྙས་ཟབས་ལྟ་བུ་བྱེད། དམ་པ་ཉིད་ནས་ངེད་ཀྱིས་སླར་ཧོབ་ཏོའི་མཁན་པོ་བྱེད་དགོས། ཨ་ལ་དར་ཟེར་བའི་ས་འདིར་ཡང་དགོན་པ་ཞིག་འདེབས་དགོས་ཞེས་འབྱུང་འགྱུར་རྗེན་པར་གཟིགས་པའི་གསུང་དྲང་པོར་ཕེབས་ནའང་། སྐབས་དེའི་སྐད་ཆོད་ལ་དེ་འདྲ་ཞིག་ཡོང་ཚུལ་ཤེས་བྱར་མི་སྲིད་པ་ལྟ་བུ་དང་། ཡིད་ཀྱི་དགུ་ནའང་མེད་པ་ཞིག་ཡིན་སྐབས་ཕལ་མོ་ཆེ་བཞད་གད་དུ་བྱེད་དེ། འཇམ་མགོན་ས་པཎ་གྱིས། ནང་དུ་ཡོན་ཏན་ཀུན་ལྡན་ཡང་། །ཆ་ལུགས་ངན་ན་ཀུན་གྱིས་བརྙས། །གསུངས་པའི་དཔེར་སྣང་ངོ་། འོན་ཀྱང་འབྲི་ཤིང་ལས། །སྤྲིན་གྱིས་ཡོང་ཡང་གཟའ་ནང་ན། །ཀུ་མུད་ལྡན་ལ་ཟླ་བ་སྡུག །ཅེས་གསུངས་པ་བཞིན་བླ་མ་བློ་བཟང་རིན་ཆེན་དཔལ་བཟང་པོ་དེ་ཉིད་ནས་བུམ་ནང་གི་མར་མེ་བཞིན་དམ་པ་འདི་ཉིད་ནང་དུ་ཉམས་རྟོགས་ཀྱི་ཡོན་ཏན་ལ་མངའ་འབྱོར་བ་མཁྱེན་ཏེ། འདི་ནི་སྐྱེས་བུ་ཕལ་བ་ཞིག་མིན་ཞེས་མཐོང་གཟོས་ཆེ་བར་མཛད་ཅིང་སྤྱན་གྱི་འབྲས་བུ་བཞིན་དུ་བསྐྱངས། དམ་པ་འདི་ཉིད་དྲུང་ནས་དབང་རྡོ་རྗེ་འཕྲེད་པ་ཞེས་རྡོ་རྗེ་རྣལ་འབྱོར་མས་ཨ་བྷྱ་ཀཱ་ར་ལ་དངོས་སུ་སྩལ་བ་རྒྱུད་སྡེ་བཞིའི་དཀྱིལ་འཁོར་གྱི་འཁོར་ལོ་ཧྲག་བསྡུས་ཀྱི་སྨིན་བྱེད་དབང་གི་རིམ་པ་བཀླན་གྱི་ཀྲི་ཡ་དང་སྦྲགས་པ་ཡོངས་སུ་རྫོགས་པར་གསན། གསང་ཆེན་རྒྱུད་སྡེའི་རྒྱ་མཚོར་ཞུགས་ནས་དངོས་གྲུབ་ཀྱི་རྩ་བ་དམ་ཚིག་སྤྱི་དང་བྱེ་བྲག་མཐའ་དག་མིག་གི་འབྲས་བུ་བཞིན་དུ་བསྲུངས། སྐབས་ཤིག་ནས་ཨུལ་ཡ་སུ་ཐའི་མཁར་གྱི་ཉེ་འཁོར་དུ་བྱོན་ནས་དེར་བཞུགས།

Гавьтай хөрөнгөгүй тул оньсыг нь ойлгоогүйчүүд дээрэлхдэг байв. Дээдэс өөрөө “Би бээр жич Ховдын хамба болох хэрэгтэй, Алдар хэмээх газар нэгэн хийд байгуулах хэрэгтэй” хэмээн ирээдүйг илэрхий болгоосон зарлиг шууд айлддаг ч тухайн үед тийм болохыг нь мэдэхгүй, тийм болно гэсэн бодол сэтгэлийн угт нь ч байхгүй олонх шоолдог байсан бөгөөд Зөөлөн итгэлт Сажа бандида бээр: “Дотроо эрдэм бүхнийг төгсгөсөн ч, Харагдах байдал нь муу бол бүгд доромжлох” гэж айлдсанчлан болой. Гэвч Найлзуур модноос: “Үүлэнд халхлагдсан ч гарагуудын дотроос Гүмүдаан цэцэрлэгт саран үзэсгэлэнтэй” хэмээн айлдсанчлан багш Лувсанринчэн сайн цогт тэрээр бумбын доторх зул мэт тэрхүү дээдэс дотоод бясалгал онолын эрдмийг эрхшээснийг болгоож энэ нь эгэл нэгэн төрөлхтөн бус хэмээн үзэж ихэд ачлан нүдний цэцгий мэт тэтгэв. Энэ дээдсийн өмнөөс Нархажид бээр Абъягара-д бодитой соёрхсон Очир эрих хэмээх дөрвөн дандрын хот мандлын хүрдийг багцлан боловсруулан үйлдэгч авшгийн зэрэг, бүтээх арга лугаа хавсруулан бүрэн гүйцэд сонсов. Их нууц дандрын аймгийн далайд ороод шид бүтээлийн үндэс тангараг ерөнхий болон ялгамжаатай бүгдийг нүдний цэцгий мэтээр сахив. Заримдаа Улиастай хотын ойролцоо залран тэнд оршсон.

དགུང་ལོ་ཉེར་བརྒྱད་ཀྱི་སྐབས་ཞུབ་ཅིག་མནལ་ལམ་དུ་ཚེས་གསུམ་གྱི་ཟླ་ཚེས་ལྟ་བུ་མང་དུ་བརྩེགས་ཏེ་ལྷ་ལམ་ཡོངས་སུ་གང་བའི་དབུས་ན་དཔལ་རྡོ་རྗེ་འཇིགས་བྱེད་ཀྱི་ཕྱག་མཚན་དགྲ་སྟ་ཡུ་བ་དམར་པོ་རྩེ་མོར་སྣ་ཚོགས་རྡོ་རྗེ་རྩ་བར་རྡོ་རྗེ་རྩེ་ལྔ་པས་མཚན་པ་ཞིག་མཐོང་བ་དང་། ཉེར་དགུའི་སྐབས་ལུག་ཕུག་དམར་པོ་ཞེས་པའི་རིའི་གཡོན་ཟུར་དུ་གུར་ཆེ་བ་བཞི་ཡོད་པའི་མདུན་མའི་ནང་དུ་དངུལ་དཀར་ལས་གྲུབ་པའི་ཐབ་ཤིན་ཏུ་ཆེ་ཞིང་བརྟན་ལ་ཡིད་དུ་འོང་བ་ཞིག་ན་སོལ་བ་ཁ་ཤས་ཡོད་པ་རྣམས་དོར་ནས་ཐབ་དེ་ཁྱེར་འོང་བ་ཞིག་མཐོང་བ་སོགས་ནས་བཟུང་སྙན་གྲགས་རྒྱས་ཏེ་ཡུལ་མི་རྣམས་གུས་པ་ཇེ་ཆེ་དང་འཕྲིན་ལས་ཇེ་རྒྱས་སུ་སོང་སྣང་བས། མནལ་ལམ་དེའང་བཅོམ་ལྡན་འདས་གཤིན་རྗེའི་གཤེད་ཀྱི་འཕྲིན་ལས་ལ་བརྟེན་ནས་ནག་ཕྱོགས་ཀྱི་བདུད་སྡེ་ཕམ་པར་བྱས་ཏེ་གཞན་ཕན་འཕྲིན་ལས་ཀྱི་འོད་སྣང་དཀར་པོ་ཡར་ཚེས་ཀྱི་ཟླ་བ་བཞིན་གོང་འཕེལ་དུ་འགྲོ་བ། ཟང་ཟིང་གི་འབྱོར་བ་ཇི་ཙམ་རྒྱས་ཀྱང་དཀོར་སྒྲིབ་ཀྱི་རྐྱེན་མི་འགྱུར་བར་རྣམ་དཀར་རླབས་པོ་ཆེ་སྒྲུབ་པའི་ཐབས་སུ་འཁྱེར་བས་དད་ལྡན་སྦྱིན་བདག་རྣམས་ཀྱི་སྡིག་ལྟུང་ལྷག་མེད་དུ་བསྲེག་པ་སོགས་ཀྱི་མཚོན་དོན་ཞིག་ཡིན་ནམ་སྙམ། དེ་ནས་མཁན་པོ་གུ་ཤྲི་ཆོས་རྗེ་དང་། དབེན་པར་སྒྲུབ་པ་ལ་གཞོལ་བ་གུ་ཤྲི་མཐུ་སྟོབས་རྣམ་གཉིས་ཀྱི་དྲུང་ནས་ལྷག་ལྷ་དུ་མའི་རྗེས་གནང་སོགས་འདོན་ཆོས་མང་དུ་གསན། དགུང་ལོ་སོ་གསུམ་གྱི་དུས་རྒྱལ་བའི་བསྟན་པ་ཡོངས་ལ་གཞན་དྲིང་མི་འཛོག་པའི་མཁྱེན་པ་ཅན་ནམ་ཆེ་གུ་ཤྲི་དཔལ་རྡོ་རྗེ་ལས་བཅོམ་ལྡན་འདས་རྡོ་རྗེ་འཇིགས་བྱེད།

Хорин найман настай байх үеийн нэгэн шөнийн зүүдэнд шинийн гуравны сар олон давхраар огторгуйг дүүргэн буйн төвд Цогт Ямандагын мутрын барьц улаан шүрэн сүхний үзүүрт элдэв очир, сууринд нь таван үзүүрт очир тэмдэгтэй нэгнийг зүүдэлсэн ба Улаан хуц хэмээх уулын зүүн захад дөрвөн их гэр байгаагаас урд талынх нь гэрт цагаан мөнгөөр урласан маш том, бат бөх, сэтгэлд зохистой нэгэн тулганд зарим нүүрс буйг нь орхиж тэр тулгыг авч ирж буй нэгийг зүүдэлсэн тэргүүтнээс эхлээд яруу алдар нь дэлгэрч нутгийн ардын бишрэл улам ихсэж, үйлс нь улам дэлгэрсэн мэт үзэгдэх тул тэр зүүд нь ч Ямандага бурхны үйлсэд дулдуйдаж хар зүгийн шимнусын аймгийг ялж бусдад туслах үйлсийн цагаан гэрэл шинийн саран мэт дээш арвидан одох, эд тавaар хэчнээн арвидсан ч гор түйтгэрийн шалтгаан бололгүй, цаглашгүй их буяныг бүтээхийн аргад авснаар сүсэг төгөлдөр өглөгийн эздийн хилэнц унал үлдэгдэл үгүй шатаагдах тэргүүтнийг бэлгэдсэн утга мөн болов уу хэмээнэ. Түүнээс хамба гүшри цорж хийгээд аглагт бүтээлд зүглэсэн гүшри Түдэв хоёрын өмнөөс үлэмжийн бурхан олны даган соёрхол тэргүүтэн уншлага ном олныг сонсов. 33 настайдаа бурхны шашин огоотод бусдыг үл шүтэх айлдалт номч гүшри Балдоржоос Ялж төгс нөгчсөн Ямандага,

རྟ་མགྲིན་ཡང་གསང་། སྤྱན་རས་གཟིགས་སོགས་ཀྱི་དབང་དང་། སྒྲུབ་ཐབས་རིན་འབྱུང་གི་རྗེས་གནང་ཡོངས་སུ་རྫོགས་པ་གསན། འདི་དག་གི་སྐབས་སྔ་ཕྱི་ཀུན་ཏུ་ཆོས་གསན་པ། དཔེ་ཆ་འཛིན་སྐྱོར། ཐུགས་དམ་བཟླས་བརྗོད། ཕྱག་དང་མཆོད་པ་སོགས་ཆོས་སྤྱོད་རྣམ་བཅུ་ཡ་མ་བྲལ་བར་མཛད་པས། བཀའ་གདམས་གླེགས་བམ་དུ། ང་ཐོས་དུས་ཙ་ན་བསམ་སྒོམ་བསྒོ། །བསམ་དུས་ཙ་ན་ཐོས་སྒོམ་བསྒོ། །གསུངས་པ་བཞིན་ཐོས་བསམ་སྒོམ་གསུམ་ལྷན་དུ་མཛད་པས་གཞུང་ལུགས་རྒྱ་མཚོའི་དོན་ལ་མཁྱེན་རབ་ཀྱི་སྣང་རྟོལ་ཞིང་ཉམས་རྟོགས་ཀྱི་ཡོན་ཏན་དབྱར་མཚོ་བཞིན་དུ་རྒྱས། གདུལ་བྱ་འཕྲིན་ལས་ཀྱང་ཆེར་རྒྱས་ཏེ་དད་ལྡན་གྱི་གྲྭ་སློབ་སྤྲིན་བཞིན་འདུས། ནད་པ་ཉམ་ཐག་འགའ་ཞིག་སོགས་མགོན་མེད་པ་རྣམས་ཀྱི་མགོན་མཛད་ཅིང་། ལེགས་ཉེས་ཀྱི་བླང་དོར་སོགས་གསལ་བར་ལུང་བསྟན་པས། གྲགས་སྙན་གྱི་རོལ་མོ་ཕྱོགས་ཀུན་ཏུ་ཁྱབ་བོ། །ཁྱད་པར་དུ་དགུང་ལོ་སོ་དྲུག་པ་ཆུ་བྱིའི་ལོར་བྱང་ཕྱོགས་སྐྱེ་དགུའི་འདྲེན་མཆོག་རྗེ་བཙུན་དམ་པའི་ཞབས་ལ་མཇལ་བར་དགྱེས་པའི་བཀའ་མཆིད་མང་དུ་གནང་ཞིང་བརྩེ་གཟིགས་ཆེ་བར་མཛད། བསྟན་པའི་བཙས་སུ་དགོངས་ཏེ་གདན་ལྔ་བརྩེགས་རྒྱབ་ཡོལ་དང་བཅས་པའི་གཟེངས་སྟོད་དང་། ཨེར་དེ་ནི་ཡིལ་གོག་སན་མེར་གེན་པཎྜི་ཏ་ཞེས་པའི་ཆོ་ལོ་གནང་། དངུལ་དེམ་སོགས་ཟང་ཟིང་གི་གནང་ཆའང་སྣམ་མཐོ་བ་སྩལ།

Дамдинянсан, Жанрайсиг тэргүүтний авшиг болон Бүтээх арга Раднасамбавын даган соёрхол бүрэн гүйцэд сонсов. Эдгээрийн урьд, хойдод үргэлж ном сонсох, цээжлэх, давтах, урьж өгүүлэх, мөргөх, тахил өргөх тэргүүтэн номын арван явдлаас огт салалгүй зохиосон тул Гаадамбын дэвтэрт: “Би сонсох цагтаа санахын үүдийг зорьж, санах цагтаа сонсох дадуулахад зоримуй” хэмээн айлдсанчлан сонсох, санах, дадуулах гурвыг хамтад нь зохиосноор далай мэт сургаал номлолын утгыг машид айлдах билиг хурц бөгөөд онолын эрдэм зуны нуур мэт дэлгэрэв. Шавийн үйлс ч ихэд дэлгэрч сүсэг төгс хувраг шавь үүл мэт хуралдав. Зарим нэг авралгүй өвчтөн тэргүүтний аврал болж, сайн муугийн авал орхилыг тодруулан эш үзүүлснээр яруу алдрын хөгжим зүг бүхнээ түгвэй.

Ялангуяа гучин зургаан насны усан хулгана жилд умар зүгийн амьтны дээд удирдагч Жэвзүндамбын өлмийд золгоход баяслын зарлиг олонтоо соёрхож энэрлээр ихэд болгоон зохиов. Шашныг сахигч гэж таалаад таван давхар олбог, арын хөшиг сэлтээр ачлан, Эрдэнэ Ялгуусан мэргэн бандида хэмээх цол соёрхож мөнгөн гүц тэргүүтэн эд тавaарын соёрхлын хувь ч баглаа өндрийг хайрласан.

རྗེ་བཙུན་དམ་པའི་བཀའ་ལུང་དེ་ལ་བརྟེན་ནས་ཕྱོགས་ཉེ་རིང་ཀུན་ཏུ་ཡིལ་གོག་སན་གེ་གེན་ཞེས་མཚན་གྱིས་ཁྱབ་པར་གྱུར། ཆོས་ཀྱི་གདན་ཁྲིར་བཞུགས་པའི་བླ་མ་ཆེ་ཆུང་དང་། སྡེ་འབངས་སྟོབས་འབྱོར་ལུང་ལས་སོགས་ཀྱིས་མཐོ་བའི་དཔོན་ཁག་མང་པོ། ཆོས་དོན་དུ་གཉེར་བའི་ཚུལ་མཐུན་གྱི་གྲྭ་སློབ། ནད་གདོན་གྱིས་གཟིར་བའི་འགྲོ་བ་ཉམ་ཐག་པ་སོགས་མཆོག་དམན་ཀུན་གྱིས་གཙུག་རྒྱན་དུ་བཀུར་ཏེ་འདི་ཕྱིའི་རེ་ས་དང་བསོད་ནམས་ཀྱི་ཞིང་ས་དམ་པར་གྱུར་ཏོ། །སྐྱུ་སྔ་མའི་དུས་སོགས་སུ་༡ གོང་མ་བདག་པོ་ཆེན་པོས་མི་མཁྱེན་ཀྱང་སྐབས་འདིར་ཧོབ་ཏུའི་དམག་གི་མགོ་བ་ཨམ་བན་ཚེ་དཔག་ཟེར་བས་དམ་པ་འདི་ཉིད་ཀྱི་མཛད་ཕྲིན་སོགས་མཐོང་ནས་གུས་པར་ཡོད་པའི་ཐོག །ཀུན་ཏུ་བདེ་བའི་ལྷ་ཁང་གི་མཁན་པོ་ནཱ་རོ་པཎ་ཆེན་ཧོ་ཐོག་ཐུ་འཔོས་ནས་དེའི་ཚབ་ཅིག་སྐོ་དགོས་བྱུང་བའི་ཚེ་ཨམ་བན་གྱིས་གོང་མ་ཆེན་པོར། དམ་པ་འདི་ཉིད་སངས་རྒྱས་ཀྱི་བསྟན་པ་ལ་ཕན་ཆེ་ཞིང་ཡུལ་ཕྱོགས་ཀྱི་སྐྱེ་བོ་ཐམས་ཅད་ཤིན་ཏུ་གུས་པ་ཞིག་འདུག་པས་ཀུན་ཏུ་བདེ་བའི་ལྷ་ཁང་གི་མཁན་པོར་བསྐོས་ན་ཨེ་ཆོག་ཅེས་བྲི་ཅི་ཕུལ་བར་དགྱེས་པའི་བཀའ་བབས་ཏེ། དགུང་ལོ་ཞེ་དྲུག་པ་རྔ་ཆེན་ཞེས་པ་ཆུ་པོ་ཁྱིའི་ལོ་སྟོན་ཟླ་ར་བའི་ཡར་ཚེས་ཀྱི་དགའ་བ་དང་པོར་ཀུན་ཏུ་བདེ་བའི་ལྷ་ཁང་གི་མཁན་པོར་མངའ་གསོལ། སྔར་ཉིད་ནས་མཁན་ས་འདིར་བཞུགས་རྒྱུའི་གསུང་ཕེབས་ཐོག་ཏུ་ཁེལ་བས། དེ་དུས་བརྙས་ཐབས་བྱེད་པ་རྣམས་ཀྱང་འགྱོད་པ་སྐྱེས་ནས་ཞབས་སྤྱི་བོར་བླངས་ཏེ་སངས་རྒྱས་དངོས་ཀྱི་འདུ་ཤེས་སྐྱེས།

Богд Жавзандамбын зарлиг эш түүнд дулдуйдаж ойр холын зүг бүхэнд Ялгуусан гэгээн хэмээх алдар түгэх болов. Номын ширээнд заларсан их бага багш нар, аймгийн албат баян хүчирхэг, эш, үйл тэргүүтнээр өндөр ноёд, номыг чухалчлах ёстой зохилдсон хувраг шавь, өвчин адаар нэрвэгдсэн гаслант амьтад тэргүүтэн дээд доод бүгдээр оройн чимэг болгон хүндэлж энэ болон хойд насны горилох газар, буяны тариалангийн дээд газар болговой.

Урьд төрлийнх нь үед Их эзэн дээдэс бээр болгоогоогүй ч энэ үед Ховдын цэргийн толгойлогч амбан Цэвэг хэмээх бээр энэ дээдсийн зохиол үйлс тэргүүтнийг үзээд, бишрэн байхын дээр Түгээмэл амаржуулагч хийдийн хамба Наро банчэн хутагт жанч халаад түүнийг орлох нэгнийг томилох хэрэг гарахад амбан бээр Ихэс дээдэст “Энэ дээдэс бурхны шашинд их тустай бөгөөд нутаг орны хамаг ард машид сүсэглэдэг нэгэн тул Түгээмэл амаржуулагч хийдийн хамбад тушааж болох уу” хэмээн бичиг өргөсөнд баяссан зарлиг бууж 46 насны Их хэнгэрэг хэмээх усан нохой жилийн (1802) намрын тэргүүн сарын шинийн нэгэнд Түгээмэл амаржуулагч хийдийн хамбад өргөмжлөв. Урьд өмнө нь энэ газар хамба болно гэж байсан зарлигтай нь нийцсэнд тэр үед басан доромжлогчдод ч гэмшил төрж өлмийг нь оройгоороо авч бурхан бодитойн хуран мэдлийг үүсгэв.

དགོན་འདིའི་མཁན་པོ་སྔ་མ་རྣམས་ ༄གོང་མ་ཆེན་པོར་མཇལ་ཞུ་མ་ནུས་ཀྱང་། ཉིད་ནས་ཞུས་པར་དགྱེས་པའི་སྤྱན་བསྐྱངས་དང་གསེར་གྱི་བཀའ་བཟང་པོ་བབས། མཁན་ས་འདིར་བཞུགས་པ་ནས་བཟུང་དུར་བེད། ཇ་ཧ་ཆིང་། ཐོར་གོད། ཨུ་རི་ཡན་ཧས་སོགས་ཐམས་ཅད་ཀྱིས་བླ་མར་བཀུར། ཇི་སྐད་དུ་ལུང་ལས། དམ་པའི་མགོན་བཅས་བདེ་དང་ཆོས་ལྡན་ཞིང་། །དེ་ཡི་གྲགས་པ་ཕྱོགས་སུ་རྒྱས་པར་འགྱུར། །ཞེས་གསུངས་པ་བཞིན། བླ་མའི་ཐུགས་རྗེ་ལ་བརྟེན་ནས་ཡུལ་ཕྱོགས་དེ་རྣམས་སུ་འང་ནད་འབྲུག་མུ་གེ་སོགས་མེད་པར་བདེ་ཞིང་སྐྱིད་པ་དང་རྣམ་དཀར་དགེ་བའི་ལས་ལ་བརྩོན་པར་གྱུར། ཚང་མས་མགྲིན་གཅིག་ཏུ་དམ་པ་འདི་ཉིད་ལ་གསོལ་བ་འདེབས་ཤིང་བསྔགས་པ་བརྗོད་པ་ལྷུར་བྱེད་དོ། །སྔར་ཉིད་ཀྱི་སྦྱིན་བདག་ཧལ་ཧ་གཡས་ཟུའི་རྣ་གཉིས་ཀྱིས་གཙོས་པའི་དཔོན་ཁག་རྣམས་ནས་ཀུན་མཁྱེན་རྒྱལ་བའི་དབང་པོ་མཆོག་ལ་རྗེ་འདིའི་འཁྲུངས་རབས་ཀྱི་བཀའ་རྩོམ་ཞུས་པས་འཁྲུངས་རབས་བདུན་ཙམ་གྱི་གསོལ་འདེབས་ཤིག་གསུངས་ཡོད་ནའང་སྐབས་འདིར་གུང་ཚེ་བརྟན་རྡོ་རྗེ་དང་ཆོས་མཛད་བློ་བཟང་བསྟན་འཛིན་གཉིས་ཀྱིས་པཎ་ཆེན་ཐམས་ཅད་མཁྱེན་པར་ཞུས་ནས་འཁྲུངས་རབས་བཅུ་གསུམ་གྱི་གསོལ་འདེབས་རྒྱས་པ་ཞིག་བཀའ་རྩོམ་དང་། ཉིད་ལ་འབོབ་ལྷུག་ཆ་སོགས་ཀྱི་གནང་ཆ་དང་བཅས་གཟེངས་བསྟོད་མཛད། སྐབས་ཤིག་ཧར་ཤ་ཧའི་ཐོར་གོད་ཀྱི་དཔོན་པོ་བསྟན་སྐྱོང་དབང་རྒྱལ་གྱི་ཡུལ་ཕྱོགས་སུ་འབྲུམ་ནག་མཆེད་ཚབ་ཆེ་བས་སྐྱེ་བོ་མང་པོ་སྡུག་བསྔལ་བར་གྱུར་པའི་མགོན་སྐྱབས་ལ་དམ་པ་ཉིད་ཕེབས་དགོས་པར་ ༄གོང་མ་ཆེན་པོའི་གསེར་གྱི་བཀའ་བབ་བཞིན་ཕྱོགས་དེར་ཕེབས།

Энэ хийдийн урдах хамбууд Ихэс дээдэстэй уулзаж эс чадсан ч өөрөө айлтгасанд баясан энэрч алтан сайн зарлиг буулгасан. Хамба болсон үеэс эхлээд дөрвөд, захчин, торгууд, урианхай тэргүүтэн бүгдээр багш болгон хүндлэв. Ийн хэмээн эшээс: Дээдийн итгэл сэлт амгалан ба ном төгс бөгөөд, Түүний алдар зүгт дэлгэрэх болно хэмээн айлдсанчлан ламын нигүүлсэлд дулдуйдаж тэдгээр газар оронд өвчин хямрал, ган тэргүүтэн арилж амгалан жаргалантайгаар цагаан буяны үйлд хичээх болов. Бүгдээр нэгэн дуугаар энэ дээдэст залбирч сайшаал өгүүлэхийг хичээн үйлдвэй.

Урьд нь өөрийнх нь өглөгийн эзэн байсан халхын баруун захын хоёр хошууны голлосон хэсэг ноёдоос Хамгийг айлдагч Ялгуусны эрхт дээдэд энэ богдын төрөл дарааллын зарлиг туурвихыг айлтгаснаар долоон төрөл үеийн залбирал нэгийг айлдсан нь байгаа ч энэ үед гүн Цэдэндорж болон чоймзад Лувсандагзан хоёр бээр Хамгийг айлдагч Банчинд айлтгаснаар арван гурван төрөл үесийн дэлгэрэнгүй залбирал нэгийг зарлиглан туурвисан ба өөрт нь барсын сүүл тэргүүтнийг соёрхох сэлтээр өрнүүлэн магтан зохиосон.

Нэг удаа Хар шаарын Торгуудын ноён Данжанванжилын нутаг оронд хар хижиг их түгснээр олон амьтан зовсны аврал итгэлд энэ дээдсийг залах хэрэгтэй гэсэн Ихэс дээдсийн алтан зарлиг бууснаар тэр зүгт залрав.

སྐྱེ་བོ་བརྒྱ་ཕྲག་དུ་མ་དུས་ཀྱི་འཇིགས་པ་ལས་བསྐྱབས་ཏེ་ཕན་བདེའི་ལམ་ལ་བཀོད། སོ་སོ་ནས་ཀྱང་གསེར་དངུལ་གོས་དར་རྐང་འགྲོ་སོགས་པ་དོག་པའི་དངོས་པོ་ཡོད་དགུའི་མཆོད་སྦྱིན་རྫོགས་ལྡན་གྱི་སྦྱིན་བཞིན་དུ་གཏེརབས། འོན་ཀྱང་སངས་རྒྱས་བཅོམ་ལྡན་འདས་ཀྱིས་ལས་ཀྱི་རྣམ་པར་སྨིན་པ་ནི་མ་གཏོགས་སོ། །ཞེས་ལས་ཀྱི་འབྲས་བུ་དུས་སུ་སྨིན་ན་སངས་རྒྱས་ཀྱིས་ཀྱང་སྐྱོབ་པའི་ཐབས་མེད་པར་གསུངས་པ་བཞིན་དཔོན་པོ་དེ་ཉིད་སྔོན་གྱི་འཕེན་པ་ཟད་པའི་ལས་དབང་བཟློག་ཏུ་མེད་པར་གཟིགས་ནས་འདིའི་སྲོག་ངེད་ཀྱིས་སྐྱོབ་མི་ནུས་པར་འདུག་ཅེས་གསལ་བར་གསུངས་ཤིང་། དེས་ཡོན་ཕུལ་བ་རྣམས་ཀྱང་ལན་གྱི་ཚུལ་དུ་ཕྱིར་སློག་སྟེ་བདག་གིར་མ་མཛད། ཉིད་རང་ཡུལ་དུ་ཕྱིར་ཆིབས་བསྒྱུར་ཐལ་དཔོན་པོ་དེའང་དུས་ཆོས་ཉིད་དུ་གྱུར་པས་ཐམས་ཅད་སྔར་གྱི་གསུང་ལ་ཡིད་ཆེས་ལྷག་པར་སྐྱེས། ཡང་སྐབས་ཤིག་གོང་མ་ཆེན་པོའི་བཀའ་ཕེབས་ཏེ་ཧོ་པག་ས་རའི་ཐོར་གོད་ཀྱི་ས་ཆར་ཕྱིན་ནས་དེ་ཕྱོགས་ཀྱི་རྗེ་དཔོན་སྡེ་འབངས་མཐའ་དག་མངོན་མཐོ་ངེས་ལེགས་ཀྱི་ལམ་ལ་སྦྱར། དགུང་ལོ་ང་ལྔ་པ་ལྕགས་མོ་ལུག་གི་ལོ་༧གོང་མའི་གསེར་ཞལ་མཇལ་སྐབས་བསྟན་འགྲོ་ལ་ཕན་འདོགས་ཆེ་བར་དགོངས་ནས་དགྱེས་པ་ཆེན་པོས་གསེར་གྱི་བཀའ་ལུང་བཟང་པོ་དང་། གོས་ཆེན་སེར་པོ། བྱུ་རུའི་རྒྱན་འཕྲེང་། ཤིང་རྟ་ལྗང་གུ་སོགས་གནང་སྟེ་བཀའ་དྲིན་ཚད་མེད་པས་བསྐྱངས། འཇམ་དབྱངས་མི་རྗེའི་རྣམ་པར་རོལ་བ་ ༧གོང་མ་བདག་པོ་ཆེན་པོ་ཞབས་པད་བསྐལ་བ་ཁྲི་ཕྲག་ཁྲི་ཕྲག་གི་བར་དུ་བརྟན་པའི་ཆེད་དགོན་པ་ཞིག་གསར་བཞེངས་ཀྱི་འཕེན་པ་གནང་སྟེ།

Олон зуун төрөлхтнийг цагийн аюулаас аварч туслан амгалангийн замд оруулав. Тус бүрээс алт, мөнгө, хувцас, торго, мал тэргүүтэн байгаа бүгдийнх нь тахилын үүлс төгс төгөлдөр үүл мэт бүрхэв. Гэвч Ялж Төгс Нөгчсөн Бурхан бээр “Үйлийн тийн боловсрол хамаарахгүй болой” хэмээн үйлийн үр цагтаа боловсроход бурхан ч аврах арга байхгүйг зарлигласанчлан тэр ноёны урьдын хаягдал барагдсан үйлийн эрхийг буцаах боломжгүйг мэдээд “үүний амийг би аварч чадахааргүй байна” хэмээн тодорхой айлдаад тэрээр өглөгт өргөсөн зүйлсийг хариу буцааж, өөрийн эс болгон зохиов. Эргээд нутагтаа заларсан даруй тэр ноён ч насан эцэслэснээр бүгд урьдын айлдварт ихэд итгэцгээв.

Бас нэг удаа Ихэс дээдсийн зарлигаар Ховог сайрын Торгуудын газарт заларч тэр зүгийн ноёд түшмэд аймаг албат даяарыг сайн төрөл, гэгээрлийн замд учруулав.

Тавин таван насны төмөр хонь жилд (1811 он) Дээдсийн алтан нигууртай уулзах үест шашин амьтанд их тустайг нь болгоож их баяслаар алтан сайн зарлиг эш, их алтан хувцас, шүрэн чимэгт эрих, ногоон модон тэрэг тэргүүтэн хайрлаж зарлигийн ач цаглашгүйгээр тэтгэв. Манзушри эзний тийн цэнгэлт Их эзний өлмийн лянхуа түм түмэн галавт батжихын тухайд нэгэн хийд шинээр босгохоор шийдэж

ཨ་ཡི་ཡ་སུ་ཐའི་མཁར་གྱི་ཇང་ཇུན་ཨམ་འབན་བརྒྱུད་ནས་ ༄གོང་དུ་གྲེའི་ཅི་ཞུལ་བར་བཀའ་ལན་འདོད་པ་བཞིན་བབས་པས་ཆུ་སྦྲེལ་ནས་བཟུང་ལས་མགོ་བརྩམས་ཏེ། ལྷ་ཁང་ཆེ་བ་གཅིག་ཆུང་བ་ལྔ། འདུ་ཁང་སྒོ་ཁང་བཅས་བརྒྱད་ཀ་རྟིག་པ་ཤིང་ཆ་སོགས་སྲ་ཞིང་བརྟན་པ། བཀོད་པས་ཐོན་ཞིང་གསེར་ཚོན་བཟང་པོས་ཤིན་ཏུ་མཛེས་པ་རྣམ་པར་རྒྱལ་བའི་ཁང་བཟང་ལྟ་བུ་དང་། ཁོར་ཡུག་ལྕགས་རི་རྒྱ་ཆེན་པོ། ལྷ་ཁང་ཆེ་བའི་ནང་དུ་དུས་གསུམ་སངས་རྒྱས་ཀྱི་སྐུ་བརྙན་ཤིན་ཏུ་བྱོན་ལེགས། སངས་རྒྱས་འོད་སྲུང་གི་འཕེལ་གདུང་དང་རྗེ་བླ་མའི་དབུ་ལོ་སོགས་རིང་བསྲེལ་རྣམ་བཞིས་ཡོངས་སུ་གཏམས་པས་བྱིན་རླབས་ཀྱི་གཟི་འོད་འབར་བ། སེང་ཁྲི་རྒྱབ་ཡོལ་སོགས་ཀུང་གསེར་འོད་འབར་ཞིང་རིན་པོ་ཆེའི་ཕྲ་ཚོམ་གྱིས་སྤྲ་བ་དང་། འཁོར་ཉེ་བའི་སྲས་བརྒྱད། གནས་བརྟན་བཅུ་དྲུག་སོགས་ཀྱི་སྐུ་བརྙན་གྲངས་མཚུངས། ལྡེབ་རིས་ལ་སངས་རྒྱས་སྟོང་སྐུ། ཚེ་ལྷ་རྣམ་གསུམ་དང་སྒྲོལ་ལྗང་བཞིའི་སྐུ་བརྒྱ་ཐག་རེ། འདུ་ཁང་ནང་དུ་རྒྱལ་བའི་རིགས་ལྔའི་སྐུ་དང་བཀའ་འགྱུར་ཆ་ཚང་། སྟེང་གི་གནམ་རྒྱན་ལ་ཚེ་དཔག་སྟོང་། ཆོས་སྐྱོང་མང་པོའི་སྐུ་ཐང་སོགས་དང་། ལྷ་ཁང་གཞན་རྣམས་ལ་གསང་བདེ་འཇིགས་གསུམ་སོགས་ཡི་དམ་ལྷག་པའི་ལྷ་མང་པོ་དང་། མྱུར་མཛད་ཡེ་ཤེས་ཀྱི་མགོན་པོ་སོགས་དམ་ཅན་ཆོས་སྲུང་མང་པོའི་སྐུ་བརྙན་ཇམ་བཟེད་དང་ལྡན་ཞིང་བྱིན་རླབས་ཀྱི་གཟི་འོད་འབར་བ་རྣམས་བཞེངས།

Улиастай хотын Жанжин амбанаар дамжуулан дээш бичиг өргөсөнд хариу зарлиг зөвшөөрсөн тул усан бичин жилээс (1812 он) эхлүүлэн нэг том, таван жижиг сүм дуган, үүдний тасалгаа сэлттэй, найман баганын мод нь хатуу, бөх байгуулалт гарсан нь сайн алтан будгаар машид үзэсгэлэнтэй тийн ялгуусны сайн байшин мэт ба эргэн тойрон агуу их төмөр уул, их дуганы дотор гурван цагийн бурхны лагшны дүрс машид сайныг залсан, Одсүрэн бурхны пэлдэн, Богд ламын тэргүүний үс тэргүүтэн дөрвөн зүйлийн ринсрэлээр огоот бялхсанаар адистидын гэрэл гялбаа бадарсан.

Сэнтийний арын хөшиг тэргүүтэн ч алтан гэрэл цацарсан, эрдэнийн шигтгээгээр хээлсэн ба нөхөр шадар найман хөвгүүн, арван зургаан архад тэргүүтний лагшин тоо зохицсон. Туурганы зурагт мянган бурхны лагшин, Насны гурван бурхан, дөрвөн Ногоон дарь эхийн лагшин нэг зуу, дуганы дотор Язгуурын таван бурхны лагшин болон Ганжуур бүрэн, дээрх лавирт мянган Цэнд, номыг тэтгэгч олны лагшингийн хөрөг тэргүүтэн ба бусад дуганд Сандуй, Дэмчог, Жигжэд гурав тэргүүтэн ядам үлэмжийн олон бурхан, Түргэн Зохиогч Билгүүний Итгэл (Гомбо) тэргүүтэн тангарагт номын олон сахиусны дүр сүр жавхлан лугаа төгс ба адистидын гэрэл гялбаа бадарсан нугуудыг бүтээсэн.

ཞི་རྒྱས་དབང་དྲག་གི་ཉམས་དང་ལྡན་པའི་རྒྱལ་ཆེན་བཞི་སོགས་སྐུ་ཐམས་ཅད་ཀྱང་མདོ་རྒྱུད་ནས་གསུངས་པའི་ཆག་ཚད་དང་ལྡན་ཞིང་གཟི་འོད་འབར་བས་མིག་གི་བདུད་རྩི་ལྟ་བུར་བསྐྲུན། ལྷ་ཁང་ཐམས་ཅད་དུ་མཛོད་གོས་གསེར་མ་སོགས་ཀྱི་བླ་བྲེ་དང་། ཕྱེ་འཕྱུར་རྒྱལ་མཚན་ཀ་འཕན་སོགས་ཀྱིས་མདོན་པར་བཀྲ་བ་འཇའ་འོད་འཁྲིགས་པ་ལྟ་བུ། དབྱིབས་ལེགས་འོད་འབར་རྒྱ་བཟོ་སོགས་ཁྱད་དུ་འཕགས་པའི་མཆོད་པའི་ཡོ་བྱད་དུ་མཚར་དུ་དངས། ཕྱི་ངོས་ཀྱི་ལྷེབ་རིས་ལ་ཉེ་སྲས་བརྒྱད། གྲུབ་ཆེན་བརྒྱད་ཅུ། ཉིད་ཀྱི་འཁྲུངས་རབས་བཅུ་གསུམ་མ། མཆོད་པའི་ལྷ་མོ་མང་པོ་དང་བཅས་གོ་མཚམས་མེད་པར་བྲིས་པ་སོགས་མཐོང་ཐོས་དྲན་རེག་དོན་ལྡན་དུ་འགྱུར་བའི་བཀོད་པ་བླ་ན་མེད་པ་གནང་སྐྱེ་ཉེ་ཞོ་མེད་པར་ཐུགས་ཀྱི་བཞེད་པ་བཞིན་གྲུབ། རྟེན་བརྟེན་པ་ཀུན་གྱི་རྒྱུ་སོང་དང་། ལས་བྱེད་ཀུན་ལ་ཡོན་སོགས་གང་འོས་ཡིད་ཚིམ་པར་སྩལ་བ་བཅས་རགས་རིམ་ཕྱོགས་བསྡོམས་བགྲིས་པ་དངུལ་སྲང་ཁྲི་ཕྲག་ལྔ་ཙམ་སོང་བས་དད་ལྡན་རྣམས་ཀྱིས་ཕུལ་བའི་བདོག་པ་མཐའ་དག་བྱང་ཆུབ་སྙིང་པོ་མཆོག་གི་མཐས་གཏུགས་པར་སྨིན་པའི་བསོད་ནམས་མི་ཟད་པའི་གཏེར་དུ་བསྒྲུབས་ཏེ་འབྲེལ་ཚད་དོན་དང་ལྡན་པར་མཛད། ན་ཚོད་ལྡན་ཞེས་པ་ཤིང་མོ་ཕག་གི་ལོ་སྟོན་ཟླ་འབྲིང་པོའི་ཡར་ངོ་གཟའ་སྐར་འཕྲོད་སྦྱོར་ཕུན་སུམ་ཚོགས་པའི་དུས་ཚེས་དགེ་བ་ལ་དགེ་འདུན་རིག་པ་འཛིན་པའི་ཚོགས་དང་བཅས་པས་སྤྱན་དབྱེའི་ཆོ་ག་སྨིན་རྒྱས་ཕྱག་ལེན་རྣམ་པར་དག་པའི་སྒོ་ནས་ལེགས་པར་བསྒྲུབས་ཏེ་དམ་ཡེ་དབྱེར་མེད་དུ་བརྟན་པར་བྱས།

Амарлиулах, дэлгэрүүлэх, эрхэнд хураах, хатуу үйлийн хүчин төгс Дөрвөн махранз тэргүүтэн лагшин бүгд судар дандраас зарлигласан хувь хэмжээ лугаа төгс ба гэрэл гялбаа бадарснаар хараа булаамаар байгуулсан. Дуган болгонд луут шар хоргой тэргүүтний лавир, үнэрт хавтага, дуаз, багана, манжлага тэргүүтнээр илтэд чимэглэсэн нь солонгын гэрэл тулцсан мэт, дүрс сайн, гэрэл цацарсан, уг урлал тэргүүтэн хэтэрхий ялгамжаатайг тахилын эдэд жигдлэн өрсөн. Гадна талын тууурганд шадар найман хөвгүүн, наян их шидтэн, өөрийн (Лувсандамбадаржаа ламын) арван гурван төрөл, тахилын охин тэнгэр олон лугаа сэлтийг зай завсаргүй зурсан тэргүүтэн үзэх, сонсох, санах, хүрэлцэхэд хэрэг туст дээр үгүйг байгуулан соёрхоод барцад үгүй тааллын дагуу бүтээв. Шүтээн ба шүтэгч бүхний уг (бүтээхэд орсон эд), үйл үйлдэгч бүгдийн хөлс харамж тэргүүтэн аль зохистойгоор сэтгэлийг нь ханган хайрласан сэлтийг бүдүүн багцаагаар дүгнэхэд тавин мянган лан мөнгө болсон нь сүсэг төгөлдөр нугууд бээр өргөсөн бүгдийг бодийн дээд шимийн эцэст хүрч боловсрох барагдашгүй буяны санг бүтээн барилдлагатай бүгдийн хэргийг төгсгөн зохиосон. Насан төгөлдөр хэмээх гахай жил (1815)-ийн намрын дунд сарын шинийн гараг одны тохиол учрал хотол чуулсан цагийн өлзийт өдөр арвисыг баригч хуврагийн чуулган лугаа сэлтээр мэлмий нээх зан үйл боловсронгуй дэлгэр асар ариун гарын авлагын үүднээс сайтар бүтээж тангараг билгүүн ялгал үгүй батад үйлдвэй.

མཇུག་ཏུ་འཆམ་དང་བྱམས་པ་གླིང་སྐོར་སོགས་བྱས་པའི་ཚེ་མེ་ཏོག་གི་འདབ་མའི་རྣམ་པ་གསལ་བའི་ཁ་བ་ཅུང་ཟད་བབ་པས་ས་སྟེང་དཀར་འཇམ་དུ་བྱས། དེ་འཕྲལ་ནམ་མཁའ་ཡོངས་སུ་དངས་ཤིང་ཉི་འོད་གསལ་བས་བག་དྲོ་ཞིང་བྱིན་ཆགས་པ་སོགས་རྟེན་འབྲེལ་རང་འགྲིག་ཏུ་བྱུང་། དེ་ནས་ཧལ་ཧ། དུར་བེད། ཛ་ཧ་ཆིན། ཐོར་གོད། ཨུ་རི་ཡན་ཧས་སོགས་ཀྱི་སྦྱིན་བདག་སེར་སྐྱ་དྲག་ཞན་མང་དུ་འདུས་པ་ཐམས་ཅད་ཀྱིས་ལྷ་ཁང་རྣམས་ལ་ཕྱག་མཆོད། དགེ་འདུན་ལ་བསྙེན་བཀུར་སོགས་ལྷ་མཆོད་མི་མཆོད་རྒྱ་ཆེན་པོ་དང་། རྗེ་བཙུན་བླ་མ་དམ་པ་ཉིད་ལ་ན་བཟའ་ཞེར་སྦྲུད། དངུལ་སྲང་སྟོང་ར་ཅན་སོགས་ཀྱི་མཆོད་སྦྱིན་སྤྲོས་ཏེ་ཞབས་པད་ཡུན་བརྟན་གྱི་གསོལ་འདེབས་ཞུས། བྱིན་རྟེན་དང་དངོས་པོའི་གནང་ཆ་སོགས་གང་འཚམ་དུ་སྩལ་ཏེ་མགུ་བར་མཛད་དོ། །དེ་ལྟར་བསྟན་འགྲོ་ལ་སྨན་པའི་ཐུགས་སྐྱེད་རླབས་པོ་ཆེའི་ས་བོན་དུས་སུ་སྨིན་པའི་འཕྲིན་ལས་ཀྱི་ཡལ་ག་ཕྱོགས་བརྒྱར་རྒྱས། ཟབ་མོ་རྡོ་རྗེའི་རྣལ་འབྱོར་ལས་གཡོ་བ་མེད་པའི་ཉམས་རྟོགས་ཀྱི་འབྲས་བུ་གཡུར་དུ་ཟ། སྙན་པར་གྲགས་པའི་དྲི་བསུང་མངར་པོ་བྱང་ཕྱོགས་ཀྱི་འཛིན་མའི་ཁོར་ཡུག་ཁྱབ་པར་འགྱོ། ཐབས་མཁས་ཐུགས་རྗེའི་གྲིབ་བསིལ་སྟུམ་པོས་ཉམ་ཐག་འགྲོ་བ་ཀུན་ལ། ཕན་བདེའི་མཆོག་སྦྱིན་སྩོལ་བཞིན་པར་བློ་བཟང་རྒྱལ་བསྟན་ཡངས་པའི་དགའ་ཚལ་མཛེས་པའི་རྒྱན་དུ་འཚོ་ཞིང་གཞེས་པར་བཞུགས་ཏེ། སྲིད་ཞིའི་རྣམ་དཀར་གྱི་ལེགས་ཚོགས་མ་ལུས་པ་དར་ཞིང་རྒྱས་པའི་སྐབས་སུ་གནས་བཞིན་པ་ལགས་སོ། །

Сүүлд нь цам гаргах болон Майдар эргэх тэргүүтнийг үйлдэх цагт цэцгийн дэлбээ шиг байдалтай багахан цас орсноор газрын дээр зөөлөн цагаан болж тэр даруй огторгуй огоот тунгалагшиж нарны гэрэл тодорсноор сэтгэлд тааламжтай, адистид оршсон тэргүүтний шүтэн барилдлага өөрөө жигдрэн гарсан. Тэндээс халх, дөрвөд, захчин, торгууд, урианхай тэргүүтний өглөгийн эзэн хар шар, сайн муу олон хурсан бүгдээр дугануудад мөргөл тахил, хуврагт өргөл хүндлэл тэргүүтэн тэнгэр хүмүүний агуу их тахил болон гэтэлгэгч багш дээдэс ямагтад чухал хэрэглэх хувцас, мянгаад лан мөнгө тэргүүтний тахилын үүл дэлгэж өлмийн лянхуа өнөд батдахын залбирал айлтгаснаар (хариуд нь] адистидтай шүтээн болон эд таваар хайрлах тэргүүтэн аль зохихыг хайрлаж баясан зохиов. Тэр мэт шашин амьтанд туслах агуу их таалал үүсгэсний хөрөнгө цагтаа боловсрох үйлсийн салаа мөчир зуун зүгт дэлгэрч Гүнзгий очрын егүзэрээс үл хөдлөх бясалгал онолын үр багшиж, Яруу алдрын анхилуун үнэр умар зүгийн газрын эргэн тойрон түгэн тархаж, Мэргэн арга нигүүлслийн сэрүүн сүүдрийн нүнжгээр гасалсан хамаг амьтанд, Тус амгалангийн дээд өглөгийг хайрласаар **Сайн Оюунт** ялгуусны **шашин-ы** уудам цэцэрлэгийн үзэсгэлэнт чимэг болж амьдран сууж оршоод, Сансар нирваany асар цагаан сайн чуулган бүгд **арвидан дэлгэрэх**ийн үест оршсоор амуй.

༄ སྨྲས་པ། ནན་ཆེར་བསྐྱུལ་བའི་ནོར་རྒྱས་ཀྱིས་དྲངས་པ། །བདག་བློའི་རིན་ཆེན་རི་བོ་མནྡ་རས། །
དམ་པའི་ཡོན་ཏན་ཆུ་གཏེར་བསྲུབས་པ་ལས། །རྟོགས་བརྗོད་གསར་བའི་ཟླ་བ་འདི་འཁྲུངས་སོ། །
ལེགས་བཤད་ཛིང་བུར་འཁྱིལ་བ་ཕྱོགས་དང་མཚམས། །གང་དུ་དྲངས་ཀྱང་ཆིལ་ཆིལ་འབབ་བ་ལས། །
ངོ་མཚར་ལྦུ་བ་དཀར་པོའི་འཕྲེང་དཀྲིགས་པ། །ཆེད་དུ་བརྗོད་པའི་ཉལ་འགྲོའི་རྒྱུན་འདི་བབས། །
རྣམ་པ་གསུམ་གྱིས་བསྐལ་པའི་བཤུལ་རིང་ལམ། །ཡིད་ཆེས་ལུང་དང་བདེན་ཚིག་མཁར་བ་ལ། །
བརྟེན་ནས་སྡེབ་ལེགས་གོམ་སྟབས་བསྐྱོད་པ་འདིར། །ནོངས་པ་མཆིས་གང་མཁས་པའི་ཚོགས་ལ་འཆགས། །
རླབས་ཆེན་ཐུགས་བསྐྱེད་ཡུ་བ་རབ་བརྟན་ཅིང་། །ངེས་ལེགས་དབང་གི་རྒྱལ་པོའི་ཏོག་མཛེས་པ། །
བཤེས་གཉེན་དམ་པའི་མཛད་བཟང་གདུགས་དཀར་པོའི། །བསིལ་བར་བྱུང་ཕྱོགས་སྐྱེ་དགུས་ངལ་གསོ་མཛད། །
གནམ་སའི་ཁོར་ཡུག་འགེངས་པར་གདངས་པའི་ཞལ། །སྲིད་གསུམ་དགྲ་བགེགས་ཁམ་དུ་བྱེད་པ་ཡི། །
སྲུང་མ་ཡེ་ཤེས་སྤྱན་ལྡན་ཚོགས་རྣམས་ཀྱིས། །བསྟན་དང་བསྟན་འཛིན་སྐྱོང་བའི་བྱ་ར་མཛོད། །
འདྲེན་མཆོག་ཞབས་པད་རྡོ་རྗེའི་གཤིས་སུ་བརྟན། །མཛད་འཕྲིན་འོད་སྣང་ས་གསུམ་ཀུན་ཏུ་ཁྱབ། །

Өгүүлрүүн:
Агуу их шамдлаар дуртгасан баялгаар татагдан
Алин миний оюуны эрдэнийн уул Мандара бээр
Адбиш дээдсийн эрдмийн далайг бүлснээр
Асар шинэ цадигийн энэ саран мэндэлбэй.
Сайтар номлолын цөөрөмд хуйларсан зүг ба завсар
Сэтэлж хаагуур нь татсан ч нам нам буусаар
Сонин гайхамшигт цагаан хөөсөн эрхис бүрхсэн
Сайшаан өгүүлэх усны урсгал энд буун
Гурван байдлаар галавын хол аяны замд
Гайхалгүй сэтгэл итгэх эш ба үнэн үгийн таягт
Түшээд сайтар эвлүүлэн алхан явж хөдлөх энд
Ташаарсан алин буйг мэргэдийн чуулганд наманчилмуй.
Агуу их тааллыг үүсгэсэн иш маш бат ба
Амарлингуй нирвааны хааны оройд үзэсгэлэнт
Ачит багш дээдсийн сайн зохиол цагаан шүхрийн
Агаар сэрүүнд умар зүгийн амьтан амсхийн зохиов.
Огторгуй газрын эргэн тойрныг дүүргэн ангайсан амаараа
Орон гурван ертөнцийн дайсан тотгорыг үмхэн үйлдэгч
Омогт сахиус билгүүний мэлмий төгсийн чуулгад бээр
Огт холдолгүй шашин ба шашныг баригчдыг харуулд.
Дээд удирдагчийн өлмийн лянхуа очир мэт батжиж
Зохиол үйлсийн гэгээн гэрэл гурван газар дахинаа түгж

འཛམ་དཔལ་སྙིང་པོའི་རིང་ལུགས་ཕྱོགས་མཐར་རྒྱས། །རྫོགས་ལྡན་གསར་པའི་དགའ་སྟོན་འཕེལ་གྱུར་ཅིག །
རྩེ་གཅིག་གུས་པ་ལྷུར་ལེན་སློབ་མའི་ཚོགས། །རྒྱལ་བློན་འབངས་བཅས་ཚེ་རབས་འཕྲེང་བ་རུ། །
བླ་མ་མཆོག་གིས་འབྲལ་མེད་རྗེས་བཟུང་སྟེ། །ཡང་དག་ལམ་གྱི་བགྲོད་པ་མཐར་ཕྱིན་ཤོག །
ཅེས་བྱང་ཕྱོགས་བསྟན་འགྲོའི་ཕན་བདེའི་རྩ་ལག་དམ་པར་གྱུར་པ་ཡིལ་གོག་སན་ཨེར་དེ་ནི་མེར་གེན་པཎྜི་ཏ་ཧོ་ཐོག་ཐུ་བློ་བཟང་བསྟན་པ་དར་རྒྱས་ཀྱི་རྣམ་པར་ཐར་བ་ནོར་བུའི་མེ་ལོང་ཞེས་བྱ་བ་འདི་ནི་བསྟན་པའི་གསལ་བྱེད་དཔའ་རིས་ཞབས་དྲུང་ཨེར་དེ་ནི་མཁན་པོ་ངག་དབང་མཁྱེན་བརྩེ་སོགས་ཐུར་ཆེན་དགོན་ཐོས་བསམ་དར་རྒྱས་གླིང་གི་བླ་སྤྱི་ཐུན་མོང་ནས་སྔ་ཕྱིར་ཡང་ཡང་བསྐུལ་ཞིང་། ཆོས་རྗེ་བློ་བཟང་དཀོན་མཆོག་ངོ་གཡོག་ཆེད་གཏད་ཀྱིས་འོངས་ཏེ་བསྐུལ་བ་བཞིན། བཙུན་པ་དཀོན་མཆོག་བསྟན་པའི་སྒྲོན་མེས་རྒྱལ་བའི་ལུང་གིས་ཟིན་པའི་ཆོས་གྲྭ་ཆེན་པོ་བཤད་སྒྲུབ་བསྟན་པའི་འབྱུང་གནས་དཔལ་ལྡན་བཀྲ་ཤིས་འཁྱིལ་དུ་སྦྱར་བའི་ཡི་གེ་པ་ནི་སྔགས་རམས་པ་རཏྣ་ཨཱ་ནནྡས་བགྱིས་པ་འདིས་ཀྱང་སརྦ་པྲ་ཛ་ཀཱ་ལེ་ཁྱ་ཤྲི་ཡཿ ཤུ་བྷཾ་མ་སྟུ༔ ། །

Зөөлөн цогтын зүрхний өнө ёс зүгийн эцэст дэлгэрч
Төгс төгөлдөр шинэ баяр хурим арвидах болтугай.
Нэгэн үзүүрт бишрэлийг цохлон авагч шавийн чуулган
Нутаг орны хаан түшмэл албат сэлтийг төрөл тутамдаа
Нигуураасаа хагацуулалгүй багш дээдэс бээр тэтгэн дэмжиж
Нут бат үнэн мөрөөр зорчин эцэст нь хүрэх болтугай.

*хэмээн умар зүгийн шашин амьтны тус амгалангийн дээд садан болсон Ялгуусан Эрдэнэ мэргэн бандида хутагт Лувсандамбадаржаагийн намтар Чандманийн эрих хэмээх үүнийг шашныг гийгүүлэгч Баари хувилгаан эрдэнэ хамба Агваанчэнзэ тэргүүтэн Түрчэн хийд Тойсамдаржаалингийн лам хар олноос урьд хожид дахин дахин сануулсан ба цорж Лувсангончог эзний тухайлан тушаалаар ирээд дуртгасанчлан тойн Гончогдамбийдонмэ бээр Ялгуусны эшээр эзлэгдсэн номын их хүрээ Номлол бүтээлийн шашин гарахын орон цогт төгс Дашчил-д найруулсны бичээч нь аграмба Радна-Ананд бээр үйлдсэн үгээр цаг бүхэнд хотол чуулган өлзий хутаг орших болтугай.*

Төвөд хэлнээс орчуулсан: Т.Отгонбаяр
*Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Сурвалж бичиг, төвөд судлалын салбар*

Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/.